

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 4 дүгээр сарын 07-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-30

- 1. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/** 6-7
 - 2. Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуунаас Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэх** 7-30
-

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
4 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 11 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Болормаа, Ш.Бямбасүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Баатархүү, О.Батнайрамдал, М.Сарнай, Б.Түвшин, М.Энхцэцэг.

Хуралдаан даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар нараас ирүүлсэн хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэхийг хойшлуулах тухай хүсэлтийг танилцуулав.

Л.Энхнасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Эрүүл мэндийн сайд Э.Батшугар нараас ирүүлсэн хүсэлтийн дагуу дээрх асуудлыг хэлэлцэх асуудлаас хойшлуулах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 6
Бүгд: 19
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн тул дээрх асуудлыг хойшлуулахаар тогтов.

Нэг. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Зөвлөх А.Болортуяа, референт Б.Энхмаа нар байлцав.

Тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара үг хэлэв.

Л.Энхнасан: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 4

Бүгд: 21

81.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуунаас Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэх

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, мөн газрын Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Б.Хандсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, Зөвлөх А.Болортуяа, референт Б.Энхмаа нар байлцав.

Асуултын хариуг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан танилцуулав.

Асуултын хариутай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, О.Саранчулуун, С.Эрдэнэбат, М.Ганхүлэг, Ж.Галбадрах, Н.Алтаншагай, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, мөн яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга О.Одбаяр, Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Б.Мөнхтөр, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл нар хариулж, тайлбар хийв.

Асуулт тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуултын хариуг хэлэлцэв.

Уг асуудлыг 15 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 36 минут үргэлжилж, 29 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 75.8 хувийн ирцтэйгээр 15 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

2026 оны 4 дүгээр сарын 07-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 11 минут.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Энхнасан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос ирвэл зохих 29 гишүүнээс 18 гишүүн ирсэн байна. Гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 62,1 хувьтай байгаа тул Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 7-ны хурлыг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна. Жадамбаагийн Баясгалан гишүүн ирсэн байна. Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн байна. Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна. Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн байна. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна. Дуламын Бум-Очир гишүүн ирсэн байна. Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн байна. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн ирсэн байна. Отгоны Саранчулуун гишүүн ирсэн байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн байна. Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Дамбын Батлут гишүүн ирсэн байна. Жанчивын Галбадрах гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Мөнхтөрийн Нарантуяа-Нара гишүүн ирсэн байна. Ганбатын Хосбаяр гишүүн ирсэн байна. Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Ингээд 65,5 хувьтай ирц бүрдсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр 3 асуудал хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт Байнгын хорооны тогтоолын төсөл “Ажлын хэсэг байгуулах тухай” хэлэлцэнэ.

2 дугаарт Улсын Их Хурлын гишүүн Саранчулуунаас Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууц сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэнэ.

3 дугаарт Улсын Их Хурлын гишүүн Баатархүүгээс Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны талаар Эрүүл мэндийн сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. 3 дугаар асуудлыг хойшлуулах хүсэлт асуулга тавьсан гишүүн Баатархүүгээс болон Батшугар сайдаас ирүүлсэн байна. Энэ саналаар хойшлуулах санал хураалт явуулъя.

3 дугаар асуудлыг Хэрлэн гишүүн санал байгаа юм уу. Тэгэхээр 3 дугаар асуудлыг хойшлуулах санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалтдаа бэлдье. Энхтуяа гишүүн байхгүй байна уу? Санал хураалтад Батлут, Баясгалан, Ганбаатар, Ганмаа.

3 дугаар асуудлыг хойшлуулъя гэсэн санал хураалт. 68,4 хувиар дэмжигдлээ. 3 дугаар асуудал хойшлогдлоо.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Байнгын хорооны тогтоолын төсөл. “Ажлын хэсэг байгуулах тухай” асуудлыг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол

Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг үндэслэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1 дүгээрт. Монгол Улсын Их Хурлын гишүүн Мөнхсайхан, Мандхай, Энх-Амгалан нараас 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Одоогоор ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсэгт орох гишүүд саналаа өгсөн байгаа. Ингээд гишүүдээс өөр нэр байна уу.

2 дугаарт, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох байгууллагын албан тушаалтны тухай бүр татан оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй гээд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Найдалаа гэсэн тогтоол байгаа юм.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах ажлын хэсгийн ахлагчаар ажиллах гишүүд байна уу. Тогтоолын төсөл нь ирээгүй байна л даа. Сая нэмж орж ирсэн байна.

Ажлын хэсгийн ахлагчаар Б.Хэрлэн Монгол Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүд Ц.Мөнхтуяа, Л.Энхнасан, С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, С.Зулпхар, Н.Алтаншагай, Г.Хосбаяр гишүүн. Горимын санал байна гэсэн үү. Нарантуяа-Нара гишүүн горимын санал хэлье гэж байна. Микрофон өгье.

М.Нарантуяа-Нара: Энэ сургуулийн орчны эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн төсөлтэй холбоотой ажлын хэсгийг яг энэ орчныг илүү сайн мэддэг, багш мэргэжлийн хүн ч юм уу, энэ орчныг нь илүү сайн мэддэг, ажлын туршлагатай тийм хүн байвал яадаг юм бэ. Ажлын хэсгийн ахлагч нь гэж ярьж байна шүү. Тэгээд ажлын хэсгийн ахлагч нь тийм хүнээр солигдвол миний хувьд бас орж ажиллаж болж байна шүү.

Л.Энхнасан: Санал юм байна. Ажлын хэсэгт бол ер нь бол Галбадрах гишүүн, Сулпхар гишүүн орж байгаа юм байна. Өөр саналтай хүн байна уу. Байхгүй байна.

Санал хураая. Саяын хэлснээр ажлын хэсгийн ахлах ахлагчаар Б.Хэрлэн, ажлын хэсгийн гишүүд Мөнхтуяа, Энхнасан, Эрдэнэбат, Галбадрах, Зулпхар, Хосбаяр, Алтаншагай. Санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Мөнхсайхан гишүүн санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалтдаа та ороогүй байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. 17 гишүүн дэмжиж, 4 гишүүн татгалзсан байна. 81 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

14.21 цаг.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе.

Улсын Их Хурлын гишүүн Саранчулуунаас Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдаас хандсан асуулгын хариултыг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулна уу. Улсын Их Хурлын гишүүн Саранчулуунаас Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад хандсан асуултын хариултыг Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Бат-Амгалан танилцуулна. Сайд 5 минутад багтаж танилцуулна уу. Сайдын микрофоныг нээнэ үү. Бат-Амгалан сайд 5 минутад танилцуулна.

Э.Бат-Амгалан: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Улсын Их Хурлын гишүүн Саранчулуунаас 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад 3 чиглэлээр 3 асуулга тавьсан байгаа. Энийг бас та бүхэнд уншиж танилцуулъя.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцын 9 дүгээр зүйл хүртээмж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, орон сууц дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэхээр заасныг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар,

2. Танай яамнаас хэрэгжүүлж байгаа орон сууцжуулалт болон түүнтэй холбоотой төсөл хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрхэн хамруулж байгаа болон хөнгөлөлттэй орон сууцын хөтөлбөрт хамруулах орон сууцжуулах талаар баримталж байгаа бодлого арга хэмжээ,

3. Сүүлийн 3 жилд орон сууцжуулах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрхэн хамруулсан талаарх тоон мэдээлэл тайланг ирүүлнэ үү гэсэн ийм албан бичиг ирсэн.

Тэгээд энэ албан бичгийн дагуу бас тодорхой хариултуудыг өгье гэсэн ийм бодолтой байна.

1 дэх асуулт. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцын 9 дүгээр зүйлд заасны дагуу энэ 2026 оны 5 дугаар сарын 17-22-ны өдрүүдэд Азербайжан улсад дэлхийн хотуудын форум болно. Энэ форум бол 2 жил тутамд 1 явагддаг. Энэ удаагийн форумд 42 улсын 72 томоохон сүүлийн үед том урбан хот гэж нэрлэгдэж байгаа том хотуудын уулзалт болох юм. Энэ уулзалтад бас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын хувиар оролцоно. Энэ форумд оролцсоноор Монгол Улсад таарах хүртээмжтэй байдлын энэ аргачлалуудыг бид нар одоо энэ форумд 1 дүгээрт эндээс аргачлал, зөвлөмжүүдийг хүлээж авч, Монгол Улсын хөрсөн дээр буулгахаар ингэж ажиллаж байна. Мэдээж бид нар энд бас хөгжлийн бэрхшээлтэй хүний чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас авч хэрэгжүүлж байгаа хууль, эрх зүйн хувьд шинэчлэл хийгдэж байгаа энэ хуулиудаа бас танилцуулна. Ер нь зүгээр манай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэд хуучин Үндэсний хороо ажиллаж байсан. 20 минутын хот гэж манай Барилгын яаман дээр байгаа. Энэ Хабитат төсөлтэй бас хамтарч бид нар сүүлийн үед жишээ нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот ямаршуу чиглэлээр хөгжих юм бэ. Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүний чиглэлээр биш, энэ ногоон байгууламж, байгаль, экологи, бусад бүх салбарын хэмжээнд гарын авлагууд бас бэлдээд ажиллаж байгаа. Энэ дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой ганц томоохон ойлголтууд сүүлийн үед олон улсын хэмжээнд явж байгаа. Энэ бол ерөөсөө 5 настай хүүхэд гараад тухайн нийгмийн харилцаанд ороход тэр 5 настай хүүхэд чөлөөтэй явж болох энэ чиглэлийг л сүүлийн үед олон улсын стандартад барьж байгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл 5 настай хүүхэд харгалзах хүнгүйгээр явах ийм боломж бололцоотой хотыг байгуулна гэдэг маань эсрэгээрээ ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, асран хамгаалагчтай бас явах нөхцөлийг бүрдүүлсэн ийм чиглэлээр бас явж болно гэсэн энэ чиглэл харагдаж байгаа юм.

Дараагийн 2 дахь асуулт нь бол яамнаас хэрэгжүүлж байгаа орон сууцжуулалт болон түүнтэй холбоотой төсөл хөтөлбөрийн талаар бас асуусан байна.

2026 оны 3 дугаар сард Засгийн газрын тогтоол гарч, бид нар төрийн орон сууцыг иргэдэд түрээслэх, өмчлүүлэх, хөлслүүлэх журмыг 10 жилийн дараа шинэчлэн баталсан. Энэ журамд хуучин 8 зорилтот бүлэг байсан бол бид нар 9 зорилтот бүлэг болгож бас ажиллаад явж байна. Энэ журмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нэг давуу тал нь өнгөрсөн журмаар бол бид нар улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн орон сууцаар хангахад 5 хүртэл хувийн квот тогтоож өгснийг 10 хувь болгосон байгааг бас та бүхэнд хэлэх нь зүйтэй гэж ингэж бодож байна. Тэгэхээр өнгөрсөн хугацааны хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн төрийн бодлого бол бас 5 хувь байсан /минут дуусав/

Л.Энхнасан: Минут дуусчихлаа нэмж тайлбарлана уу.

Э.Бат-Амгалан: Тэгэхээр өнгөрсөн хугацаанд байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд рүү чиглэсэн төрийн бодлого бол 2 дахин нэмэгдэх ийм боломж бололцоог Засгийн газрын тогтоолоор, энэ журмаар бас бид нар баталгаажуулж ажиллаж байгааг бас хэлэх нь зүйтэй гэж ингэж бодож байна.

3 дахь асуулга. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд орон сууцжуулах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулсан талаарх тоон мэдээлэл, тайланг ирүүлнэ үү гэсэн байгаа.

Би бол албан бичгээр бас Саранчулуун гишүүнд бэлдсэн. Энэ хурлын дараа бас гарт нь өгье. Гэхдээ энэ хурал дээр бас товч тайлбаруудаа хийгээд явъя. Өнгөрсөн журамд заасны дагуу бид нар нийслэл Улаанбаатар хотод 1521 түрээслэх, түрээслээд өмчлөх байр, Нийслэлийн орон сууцын корпорацтай холбоотой 972 орон сууц, нийтдээ 2493 орон .../минут дуусав/

Л.Энхнасан: Асуултдаа хариулаад явахдаа дэлгэрэнгүй дахиад тайлбарлая. Одоо байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Бат-Амгалан сайд оролцож байгаа. Баяраа Төрийн нарийн бичгийн дарга, Одбаяр Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Мөнхтөр Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Гэрэл, Хандсүрэн, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн нар оролцож байна.

Ингээд танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд байна уу. Гишүүд бол үг хэлэхгүй асуулт л асуух дэгтэй. Асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү. Алтаншагай гишүүнээр тасаллаа. Баясгалан гишүүн асуултаа асууна.

Ж.Баясгалан: Маш чухал асуудлыг өнөөдөр хөндөж байна. Тэгээд түрүүн таны яриан дундаас энэ тушаал өөрчлөгдсөн, шинэчлэгдсэн гэж ойлголоо. Тийм ээ. Энэ 2017 оны 26 дугаар журам байсан. Энэ журам шинэчлэгдсэн гэж ойлгосон.

Тэгвэл 1 дүгээрт орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулахад Барилгын комиссын бүрэлдэхүүний ¼-д хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг оруулна гэж заасан байгаа. Тэгэхээр энэ хууль зүйн заалт өнөөдөр хэрэгжиж байгаа юу. Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг оруулахад ер нь ямар ямар байгууллагууд энд хамрагдсан байгаа юм. Одоо бид нар нэгэнт нээлттэй ярилцаж байгаа учраас ямар ямар төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллаж байгаа вэ гэдгээ хэлээд өгөөрэй.

2 дугаарт хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг Улсын комисс хүлээж авахыг хориглоно гэсэн байгаа. Тэгвэл үүний хүрээнд хэчнээн барилга энэ шаардлагыг хангаагүй вэ. Хэчнээн барилга байгууламжид ямар шаардлага, ямар арга хэмжээ тавьсан бэ. Энийгээ яг тоо баримттай хэлээд өгөөрэй. Одоо бид нар бүгд мэдэж байгаа шүү дээ. Энэ хүртээмжийн асуудал бол гадна талдаа шийдчихээд орц руугаа оронгуут орцондоо дахиад 4-5 шаттай байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал биш. Энэ бол хүүхдээ түрээд явж байгаа эхийн асуудал, өндөр настай иргэний асуудал, чөмөданаа чирсэн гадаадын жуулчны асуудал. Тэгэхээр энэ хүртээмж хэр шийдэгдэж байгаа юм бэ.

Дээр нь шинэчлэн баталсан төрийн өмчийн орон сууцыг иргэдэд хөлслүүлэх, өмчлүүлэх, борлуулах журмын дагуу Ногоон нуур, Солонго, Залуус 1 зэрэг орон сууцын төслүүдэд иргэдийг хамруулах ажил 8 сарын 1-ээс эхэлнэ гэсэн байгаа. Энэ дээр бас иргэдээс маш их ирж байгаа санал хүсэлт бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр болгон цахимаар оролцох боломжгүй байдаг. Гар утас болон цахим хэрэглээ байдаггүй. Бид нарт тийм боломж байхгүй байдаг. Тэгэхээр энэ дээр тогтоол тушаалаа гаргахдаа ямар үндэслэлээр гаргасан бэ. Энд хэрвээ хөдөө, орон нутгаас цахим хэрэглээгүй хүн оролцвол яаж оролцох вэ гэдэг асуудлуудыг бол маш их тавьж байна. Тэгэхээр энэ дээр яам о ямар бодол гаргасан бэ.

Тэгээд төрийн өмчийн орон сууцуудын төслүүдийн хүрээнд ер нь яг хэдий хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй иргэн орон сууц хөлслөх, өмчлөх боломжтой болж байгаа вэ. Энэ талаар хийсэн яг тоон судалгаа, тоогоо та хэлээд өгөөч. Ингээд дараа нь нэмж асууя.

Л.Энхнасан: Сайд хариулах уу. Бат-Амгалан сайд хариулна.

Э.Бат-Амгалан: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Манайхан бас нэмэлт хариултууд өгөөрэй. Тэр нөгөө улсын комисст хэдэн байр яг хөгжлийн бэрхшээлтэй, хүртээмжтэй холбоотой хэдэн байранд өнөөдрийн байдлаар өгөөгүй байгаа юм гэдэг нарийн тоогоо гаргаж өгнө биз.

Өнөөдрийн байдлаар энэ улсын комисс, ажлын комисс хүлээж авахад бол төрийн бус байгууллагуудын оролцоо нэлээдгүй байгаа. Энэ дээр бол зураг төслийн компаниуд, барилгын ассоциацийнхан, холбоодынхон бол орж байгаа. Ер нь бол яг үндсэндээ өнөөдрийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ улсын комисс хүлээж авахад ордог ийм хуулийн зүйл, заалт өнөөдрийн байдлаар байхгүй байгаа. Тэгээд 2016 оноос хойш өнөөдрийг болтол 10 жилийн хугацаанд энэ Барилгын тухай хууль бүрэн шинэчлэгдээгүй. Зөвхөн өнгөц төдий өөрчлөлтүүд, нэмэлт, өөрчлөлтүүд хэд хэдэн удаа орсон. Энэ хуулийг бид нар энэ хаврын чуулганаар өргөн барихад Хууль тогтоомжийн тухай хуулийн бүх шаардлагуудыг нь хангасан. Өнөөдрийн байдлаар Улсын Их Хуралд өргөн барихад бэлэн болоод явж байгаа. Тэгээд энэ Барилгын тухай хуульд бол энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, энэ хүртээмжийн асуудал энэ дээр нэлээдгүй хэдэн зүйл заалтууд орсон. Энэ дээр бас цаашдаа Улсын комисст хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, төрийн бус байгууллагуудаар бас 1/4 гэх нь хаашаа юм. Мэдээж энд чинь улсын комисс 20-оод хүний бүрэлдэхүүнтэй явдаг. Тэгээд 1/4 гэхээр бас нэлээдгүй хүмүүс орох байх. Ямар ч байсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ хүртээмжийн талаар мэдлэг, боловсролтой, чадвартай ийм төрийн бус байгууллагууд оруулах зүйл заалтууд явж байгаа. Тэгээд Улсын Их Хурал дээр ороод ирэхээр мэдээж манай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болсон Баясгалан гишүүн, Саранчулуун гишүүн маань энэ хууль дээр бас нэлээдгүй сууж, Байнгын хороо, бусад үе шатуудад нь бас саналуудаа хэлэх байх гэсэн ийм бодолтой байна.

Дараагийн асуудал. Жишээ нь 2028 оныг дуустал зөвхөн нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд ярихад төрийн болон олон улсын санхүүжилтээр босох төсөл хөтөлбөрүүдийн тоо нийслэл Улаанбаатар хотынх нь төсөлтэй нийлээд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамныхтай нийлээд 24 мянган орон сууц орно гэсэн ийм тооцоолол байгаа. Үүний түрүүн би ярьсан. Улсын хэмжээнд, мөн Улаанбаатарын хэмжээнд энэ журмаар 5 хувь байсныг одоо 10 хувь болгосон. Тэгэхээр одоо хамгийн ойрхон орох гэж байгаа энэ 1008 айлын орон сууцанд гэхэд 10 хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох ийм боломж бололцоо бүрдэнэ.

Дараагийн асуудал 1 минутаа нэмээд авчихъя.

Л.Энхнасан: 1 минут өгнө үү.

Э.Бат-Амгалан: Дараагийн асуудал ер нь улс даяараа бүх салбарт цахим шилжиж байгаа. Одоо ний нуугүй хэлэхэд ухаалаг гар утасгүй хүн гэж ер нь ховор болчихсон байх Баясгалан гишүүн ээ. Тийм болохоор ер нь зүгээр цахимаараа бид нар авах тэр хүнд суртал, энэ авлигын асуудал, зөвхөн дарга дагасан байр орон сууцын хуваарилалтыг бид нар цахимаар л хийхээс өөр аргагүй байгаа. Цахимд

шилжсэнээр саяын хэлдэг хүндрэлүүд буюу энэ давхцалууд арилах, ил тод болох энэ чиглэлийн асуудлуудыг бид нар сая журамдаа сайн зааж өгсөн байгаа гэдгийг бас хэлье. Нэмэлт хариулт манайхан тэр тоо.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс 5 дугаар микрофон нэмж хариулна уу. Нэр, албан тушаалаа хэлээрэй.

О.Одбаяр: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Одбаяр байна. Саяын цахим гэдэг дээр би нэмэлт хэлчихье. Цахимаар бол бид нар Хур, Дан системтэй энэ программ хангамжаа холбочхож байгаа юм. Тэгснээрээ бол иргэн хүсэлт өгч байгаа бол хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд ч юм уу, эсвэл олон хүүхэдтэй гэр бүлийн хувьд ч юм уу, ахмад настны хувьд яг тэр үзүүлэлтээсээ сонгоод иргэний регистрийн дугаараа мэдээллээ өгчихөд бусад мэдээллүүдийг бид нар Хур, Дан системээс татаж авахаар ийм программ хөгжүүлэлтээ хийж байгаа учраас яг нөгөө цахимаар бүртгэл рүүгээ орчхоод нөгөө баахан ийм сонголтууд, дээрээс нь ийм хүндрэлтэй ажиллах энэ ажилбаруудыг нь бол бид нар хасчхаж байгаа юм. Тийм учраас бол .../минут дуусав/

Л.Энхнасан: Гишүүний 2 дугаар асуулт нь байсан. Хэчнээн байгууллага шаардлага хангаагүй байна. Тоогоор хэлнэ үү гээд. Ажлын хэсэг 8 дугаар микрофон.

Б.Мөнхтөр: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхтөр.

2025 оны эцсийн байдлаар ерөнхийдөө улсын комисст бол бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог бол бүрэн хангаж ажиллаж байгаа гэж хэлж болно. 2025 оны жилийн эцсийн байдлаар 162 барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авахдаа бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж ажилласан байгаа. Мөн түүнчлэн энэ салбарын норм нормативыг шинэчлэх ажилд бол мөн иргэдийн оролцоог бүрэн дүүрэн хангаж ажиллаж байгааг гэж хэлж болно. 2025 оны эцсийн байдлаар бид нийтдээ 1159 зураг төслийг бол боловсруулсан байна. Энэ дээр бол орон сууцын барилга 408 ширхэг, үйлдвэр 59, худалдаа үйлчилгээний 131, зочид буудал гэх мэтчилэн. Энэ .../минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулна уу. 8 дугаар микрофон.

Б.Мөнхтөр: Энэ бүх зураг төслийг боловсруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог бол бүрэн хангаж ажилласан байгаа гэж хэлэх байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Тодруулга Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Түрүүн бас сайд буруу ойлгочих шиг боллоо. Хуульд байхгүй шүү гээд тэгж байна. Энэ дээр бол Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-д байгаа. Орон сууц, нийгмийн бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулахад Барилгын комиссын бүрэлдэхүүний ¼-д хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын төлөөллийг оролцуулна гээд энэ хууль дээр заачихсан байгаа шүү.

2 дугаарт ингэж худлаа ярьж болохгүй. 1 ч зөрчилгүй, 1 ч тийм байгууллага байгаагүй гэж хэлж болохгүй. Яагаад гэвэл одоо бид нар гудамжаар яваад тэр орон

сууцууд дээр нь очоод үзэж болно. Тэгэхээр бид нар алдаагаа засах нь чухал болохоос биш алдаагүй гэж худлаа ярих нь тийм шаардлагатай биш байна.

Зураг төслийн хувьд хийчихсэн байж болно. Яг гүйцэтгэл дээрээ тэгвэл тийм зөрчилтэй байгууллага байгаа юу. Би бол ор тас байхгүй гэж ойлголоо шүү. Та нар энэндээ хариуцлага хүлээх бас боломжтой юу. Би та нарт яг бодитоор үзүүлж болно.

Л.Энхнасан: Бат-Амгалан сайд хариулна уу.

Э.Бат-Амгалан: Баясгалан гишүүний асуултад хариулъя. Манай энэ Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхтөр ажлаа аваад 7 хоноогүй байгаа. Мэдэхгүй зүйлээ бол мэдэхгүй гэдгээр нь энэ Улсын Их Хурлын гишүүдийн өмнө тайлан протоколтой хурлууд дээр шулуухан хэлж байгаарай. Мэдэхгүй бол хойноос нь албан бичгээр тодруулаад өгье гэдгээ хэлж байгаарай. Ажлаа аваад нээрээ 7 хоноогүй байгаа. Тийм учраас бас заавал хариулах гээд байх ийм асуудал байхгүй гэдгийг бас хэлье. Би нарийн тоон мэдээллийг нь мэдэхгүй байна.

Саранчулуун гишүүний энэ 3 асуулгад бол манайх албан бичгээр нэлээдгүй томоохон хэмжээний юм бэлдсэн байгаа. Энэ танилцуулгад бас минут, микрофон цаг нь хүрсэнгүй. Тийм учраас би бас энэ асуулгын хариултыг албан ёсоор албан бичгээр өгнө.

Л.Энхнасан: Нэмж тодруулъя. Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Яг зөв шүү дээ. Ингээд бүгдээрээ мэдэх мэдэхээ, мэдэхгүйгээ мэдэхгүй гэж хариулахгүй бол ингээд бөөрөнхий дандаа хариулаад, энэ нь өөрөө өрөөсөө хэрэгжээд яваад байж болохгүй.

2 дугаарт гэвэл энэ цахим дээр та нар бодоод үзээрэй. Энэ дээр Монгол Улсын бүх иргэн ухаалаг гар утастай болсон уу гэвэл үгүй. Сард 302 мянган төгрөгийн тэтгэмж авч байгаа асран хамгаалагч ухаалаг гар утас авах боломжгүй. Тэр хүмүүс хоолоо, махаа яаж хүргэе дээ гэж байгаа хүмүүс маш олон байгаа. Сая би 21 аймаг тойроод хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзсан. 4000 гаруй санал хүсэлт ирсэн. Үүний дагуу би бас албан бичгээр та нарт яг мэдээллийг нь өгье. Хэчнээн гар утасгүй хүн байгаа юм. Хэчнээн цахимдаа орж чадахгүй хүмүүс байгаа юм. Тэр талаар бас бүгдээрээ яг шударга байгаад, ойлголцоод энэ дээр бас гарц гаргалгаа юу байна. Энэ дээр бид нар хяналт тавиад ажиллачих боломж бас байна шүү дээ. Тийм биз дээ.

Л.Энхнасан: Мөнхтөр дарга хариулах юм уу. 8 дугаар микрофон.

Б.Мөнхтөр: Уучлаарай. Баясгалан гишүүнд бас буруу ойлголт бол өгсөн байна. Би бол нөгөө барилга байгууламж, зураг төсөл, норм норматив талаасаа бүх юм төгс болчихсон гэдэг агуулгаараа хэлээгүй. Би бол зөвхөн 2025 оны гүйцэтгэлийн тоо баримтыг танд бол хэлсэн байгаа. Ер нь бол бид нар зөрчил байгааг бол ойлгож байгаа. Цаашдаа зураг төсөл талаасаа, барилга байгууламж талаасаа энэ бүх зөрчлийг арилгаж ажиллана гэдгээ л илэрхийлж байгаа юм шүү. Баярлалаа.

Л.Энхнасан: Нэмж тэгэхлээр тоотоор бол мэдээллийг нь өгнө гэж ойлголоо. Саранчулуун гишүүн асуултаа асууна уу.

О.Саранчулуун: Баярлалаа. Асуултуудын хариултыг материал авсан. Тэгэхдээ тодруулахгүй бол болохгүй хэдэн зүйл байгаа.

Түрээсийн орон сууцын журмыг бид нар харсан. Тэгэхдээ журам дотор ялгаварлан гадуурхсан нэг агуулга байна гэдэг ийм хүсэлт иргэдээс бас ирж байгаа. Тэр нь юу вэ гэхээр эрх зүйн чадамжтай гэдэг хүмүүсийг оруулна гэсэн байгаа юм. Тэгээд эрх зүйн чадамжтай, чадамжгүй 2-ын хооронд ямар ялгаа гарчхаад байгаа вэ гэхээр оюуны бэрхшээлтэй 700 гаруй хүн бол эрх зүйн чадамжгүй гэсэн ийм тоо байдаг юм байна. Тэгээд оюуны бэрхшээлтэй хүмүүсийн хувьд бол насан туршид нь хэн нэгэн хүн асарч харахгүй бол бас 1 хүн ажилгүй байдаг ийм асуудал байгаад байгаа. Тэгээд энийг ер нь яаж шинэчилж, сайжруулах вэ. Ямар арга судалж байна гэдгийг тодруулчихъя гэж бодож байгаа.

Дараагийнх нь ер нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.2-т ийм заалт байгаа байхгүй юу. Тэр нь юу вэ гэхээр энгийнээр бол Засаг дарга нарын оролцоог бас тодруулсан байгаа. Засаг дарга болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг орон сууцтай болгох асуудал дээр анхаарна гэсэн ийм хуулийн заалт байгаа. Та хэд бас тодруулж үзэх юм бол. Тэгээд яг энэтэй холбоотой тоон мэдээлэл дээр би аймаг, дүүргүүдийн мэдээллийг бас яг нарийн хараагүй байгаа. Тэгэхээр аль аймаг, дүүрэг энэ дээр илүү анхаарч байна вэ гэдэг мэдээллийг бас хүсэж байна.

3 дугаарт нь саяхан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадварын нийгэм хүн ам зүйн нэлээн өргөн судалгаа хийсэн байгаа. Манай агентлаг энэ тэр нэлээн хийсэн дээ. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал дээр. Тэр судалгааны тайлангаас орлогын чадамжийн дүр төрх гарсан байх ёстой. Хэн хэдэн төгрөгийн группийн мөнгө аваад, давхар ажил хийдэг ямар боломжтой, боломжгүйг судалсан ийм тайлан байх ёстой. Тэгэхээр бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чинь дандаа группийн мөнгө аваад, гэртээ байдаггүй. Бас ажил хийдэг хүмүүс олон байгаа. Тэгэхээр тэр орлогын чадамж тооцоо гарч байж энэ түрээсийн орон сууцад хамрагдах, түрээсийн бодит төлбөр тооцоо гармаар байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ судалгааны үр дүнг би энэ агентлаг ирсэн байгаа дээр бас асуумаар байна.

4 дүгээрт нь Ногоон нуурын зорилт бүлэгт 250 гаруй гэж байгаа. Квотыг 10 хувь болгосон нь маш сайн хэрэг. Тэгэхээр 250-аас 10 хувь гэхээр 25 хүн байранд орох нь. Тэр 25 хүнийхээ шалгаруулалтыг сонгон шалгаруулалтаа яаж хийх юм бэ гэдэг нь одоо хүлээгдээд байгаа юм байна л даа. Тэгээд энэ дээр бас хариулт аваад, тэгээд тодруулъя.

Л.Энхнасан: Бат-Амгалан сайд.

Э.Бат-Амгалан: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Манайхан 2, 3 дугаар асуултад нь хариулна биз. Эрх зүйн чадамжтай гээд яах вэ зүгээр тэр журам дээр орчихсон. Гэхдээ мэдээж хөгжлийн бэрхшээлтэй иргэн таны хэлж байгаа сая 700 гаруй гэдэг тоо, тэр дээр бас бид нар давхар энэ Төрийн орон сууцын корпорацын яг энэ журмыг хэрэгжүүлэх ТУЗ гээд зөвлөл гарчихсан байгаа. Энэ дээр бол бас тодорхой хэмжээнд тэр Баясгалан гишүүний асуултад хариулахад хүртэл бас давхар хариулж байгаа. Яагаад гэхээр тэр нөгөө цахимаар орж болохгүй, чадахгүй байгаа, хүртэхгүй байгаа тэр хүмүүсийн асуудлыг нь энэ ТУЗ-ийн эрхэд

өгсөн байгаа. Тэгэхээр таны асуудаг асуулт зөв. Энэ дээр бас бид бас нарийвчилж журамдаа бас оруулъя гэсэн ийм бодолтой байна. Зөвхөн нөгөө эрх зүйн чадамжгүй гээд ингэчихээр зөвхөн тэр хувь хүний асуудал биш, хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүнийг халамжилдаг гэр бүл гээд бас орчихсон байгаа юм. Тэгэхээр бүх хүмүүс хамрагдах ийм боломжтой гэж ойлгож болно.

Сүүлийн асуулт. Ногоон нуур гээд 1008 айлын орон сууц. Та хэд минь нэг юмыг маш сайн ойлгоорой. Энэ төрийн өмчийн орон сууцыг түрээслэх, өмчлөх, хөлслүүлэх журам дотор энэ төсөл болгон маань бас өөр өөр байгаа юм. Энэ 1008 айлын Ногоон нуур нэртэй төсөл маань БНХАУ-ын Засгийн газрын 100 хувийн буцалтгүй тусламжаар баригдсан. Хятадын Засгийн газар манайд шаардлага тавиад, анх 100 хувийн буцалтгүй хөрөнгө оруулахдаа гэрээ хийсэн байдаг юм. Энэ нь болохоор зөвхөн энэ байрыг газраар солино. Газарт орсон иргэд дараагийн төсөл хөтөлбөрүүд явна. Ингэснээр нийслэл Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрөл, нөгөө утаа, яндангийн асуудал гэж ийм явж байгаа. Солонго 1, 2 гээд төслүүд энэ 2026 онд 50 хувь нь, 2027 онд 50 хувь нь орохоор 5002 айлын төсөл явж байгаа. Энэ болохоор зээл учраас бид нар тэр дээр харин засаг, Монголын талын зээл хүлээн авагч тал тэн дээр өөрсдийнхөө түрээслэх, борлуулах, хөлслөх журмаа өөрснөө гаргана. Тэгэхээр 1008 дээр бол дараагийн ээлжийн төсөл хөтөлбөр хэрэгжиж яндан буулгах ийм л асуудал байгаа юм. Тэгэхээр энэ 1008 дээр бол бид нар түр журмаар түрээслэх, нөгөө газраа өгөөд би наана чинь орохгүй. 1008-д орохгүй. Би энэ Сонгинохайрхан дүүргийнхээ энэ газар дээр олон жил амьдарчихсан учраас би энэ дээрээ амьдарна гэж байгаа хүмүүс тэнд 1008 дээр 3 жилийн хугацаанд .../минут дуусав/

Л.Энхнасан: Ажлын хэсгээс 2 дугаар микрофон хариулах уу. Гэрэл дарга хариулах уу. 1 дүгээр микрофон.

Д.Гэрэл: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Гэрэл. Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Ер нь 107 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдгийн 89 мянга нь 16-65 насны буюу хөдөлмөр эрхлэх боломжтой гэсэн ангилалд хамаарагдаж байгаа. Эдгээр иргэдийн 18 хувь нь байнгын хөдөлмөр эрхэлж, ажлын байртай байна гэсэн судалгаа байгаа. Тэгэхээр нийт иргэдийн маань 19 мянга орчим нь тогтвортой орлоготой байна гэсэн үг. Өнгөрсөн жил бид нар сая гишүүний ярьдаг судалгааг хийсэн. Энэ судалгааны үндсэн зорилго нь бол хөдөлмөр эрхлэх сонирхлыг нь тодорхойлохыг зорьсон судалгаа. Энэ судалгаанд бол 50 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан. Эдгээр иргэд бол ер нь хөдөлмөр эрхлэх нь хангалтгүй. Тэгээд 13 мянга нь цаашид хөдөлмөр эрхлэх сонирхолтой байна гэсэн. Энэ дээрээс нэмэлтээр хэлэхэд 2022 оноос хойш манай хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар .../минут дуусав/

Л.Энхнасан: Нэмж хариулъя. 1 дүгээр микрофон.

Д.Гэрэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс орон сууцад орох хүсэлтийг авч эхэлсэн байгаа. Өнөөдрийн байдлаар 740 орчим өргөдөл ирсэн. Энэ өргөдөл дээр бид нар бас дүн шинжилгээ хийж үзсэн. Одоо хэчнээн нь түрээсийн төлбөр төлөх боломжтой байна вэ гэж үзэхэд 1/3 орчим нь бол бас түрээсийн төлбөр төлөх боломжтой. 2/3 нь бол боломжгүй гэсэн дүн шинжилгээг бид нар хийчхээд байгаа.

Л.Энхнасан: 2 дугаар асуулт. Орон нутаг, аймгуудын тоо. Ажлын хэсгээс хариулах уу. Бичгээр гаргаж өгөх юм уу. Тодруулах уу. Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Баярлалаа. Тэгэхээр нөгөө 1/3 нь түрээслэх боломжтой гэдэг дээр сард хэчнээн төгрөг төлөх боломжтой ба ипотекийн юм уу, эсвэл бага орлоготой зээлийн орон сууцын хамгийн доод төлбөр хэд байх 2-ын харьцааг бид нар тооцох хэрэгтэй болчихоод байгаа.

Дээрээс нь энэ Монголбанкны өр, орлогын харьцааны Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан өр орлогын харьцаа бас байгаа шүү дээ. Энэ 3 зүйлийг бид нар жинлэж үзэж байж хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирсон гэдэг юм уу, авч чадах тэр орлогод нийцнэ гэдэг концепц чинь гарч ирэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ тооцоог ийм бүдүүн баргаар биш, илүү нарийн гаргахыг би хүсэж байна.

Дараагийнх нь бид нар энийг зөвхөн гэр бүлийн яамны асуудал, Барилгын яамны асуудал гэж бодож болохгүй юм байгаа юм. Тэгэхээр Засаг дарга нарынхаа тайланг дэлгэрүүлж авцгаая.

Л.Энхнасан: Баярлалаа. Эрдэнэбат гишүүн асуултаа асууна уу.

С.Эрдэнэбат: Чухал асуудал хөндсөн Саранчулуун гишүүндээ баярлалаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц гээд аваад үзэхээр би саяхан Эрдэнэтийн 18 дугаар сургуульд орсон юм. Орхон аймгийн. Тэгээд тэнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд маань удаан хичээл дээр сууж чадахгүй учраас түр зуур амраах гээд байранд байлгах гэсэн нийгмийн ажилтан дундуураа ийм таславч хийгээд хөөрхий 2, 3 хүүхдүүдийг байлгаж байна лээ л дээ түр. Тэгэхээр манай ерөнхий боловсролын сургуулиуд маань энэ хөгжлийн бэрхшээлтэй сурч чадах гээд тэмүүлж байгаа энэ хүүхдүүдэд зориулсан энэ барилга байшин, энэ зураг төсөл байгаа шүү дээ манай сургууль барих. Энэ дээр яг энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг түр саатуулах, тэгээд нөгөө шат, юутай холбоотой зураг төсөл хийж байна уу. Ихэвчлэн шинэ баригдаж байгаа барилгуудыг харахаар яг тэр нь орхигдчихсон зураг төслүүд байгаа. Одоо 1 загварын зургууд гээд 320 хүүхдийн, 640 хүүхдийн зургууд яваад байгаа. Тэр дээр бол тийм юм ерөөсөө харагдахгүй байгаад байгаа. Энэ талаар тодруулж асуумаар байна.

Хоёрдугаарх нь, миний алхдаг гэх юм уу даа. Чингисийн өргөн чөлөө хамгийн их хүмүүс алхдаг. Энэ дунд чинь л нөгөө хөгжлийн бэрхшээлтэй хүн байтугай эрүүл хүн явахад ер нь тун хэцүү байна. Бүр явж байхад замд нь машины зогсоолууд явган хүнийх нь зам дээр нь тавьчихсан. Бүр тэр замд нь явж байсан чинь манай Эрүүл мэндийн яам үүдэндээ баахан машинууд зогсоочихсон. Тэгээд үндсэндээ өргөн нь бол 50см л дээ. 50см зам дээгүүр хөгжлийн бэрхшээлтэй, сурон уначихсан, дугуй уначихсан, тэгээд ахмад хүмүүс зөрнө гэдэг бол тун хэцүү. Та хэд тэрүүгээр алхдаг бол алхдаг хүмүүс нь бол мэдэх байх.

Тийм учраас үүнтэй холбоотойгоор бид нар яах вэ гэхээр дэд бүтцийнхээ юман дээр явж, бодит байдлуудтай бол нэлээн танилцмаар байна. Манай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн агентлаг энэ тэр. Би уржигдар бичиг өгсөн. Энэ замаа байхгүй болго. Энүүгээр чинь маш олон хүн зорчиж байгаа, хүүхэд ч зорчиж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй ч хүн зорчиж байгаа. Тэгэхээр энэ иргэдийнхээ явах энэ зам дээр нь нэлээн анхаарал хандуулах ёстой. Тэгээд энийг бол манай

барилгын яам, Бат-Амгалан сайд та энэ тал дээр нь шаардлага өгөөд, бас эрх хэмжээ байгаа бол тэр талаар нь ажиллаач ээ гэж хэлмээр байна.

2 дугаарт орон сууцын фонд гээд нэг юм байгаад байдаг санагдах юм. Энэ байна уу, байхгүй байна уу. Зорилтот бүлэгт суурилсан дахин төлөвлөлтийн юман дээр чинь юм байна уу, үгүй юу. Би сураг сонсох нь ээ, зарим дахин төлөвлөлт дээр баахан нөгөө үнэтэй байр барьдаг нөхдүүд л очоод аваад л, үнэтэй л зарах гээд байгаа юм шиг байна. 4, 5 сая гэнэ үү, 6 сая гэнэ үү. Цаашаа өсөх байх л даа. Энийг чинь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ядарсан зүдэрсэн тэр зорилтот бүлгийнхэн чинь авч чадахгүй угаасаа. Тийм учраас энэ тал дээр тодорхой бүс нутаг, тодорхой дахин төлөвлөлт дээр ийм хүмүүст зориулаад тэр лифт, аваарын шаттай нь холбоотойгоор энэ зүйлүүдийг нь иж бүрнээр нь шийдэж тавихгүй бол бид нар энд тэндхийн төсөлтэй .../минут дуусав/

Л.Энхнасан: Бат-Амгалан сайд хариулна уу.

Э.Бат-Амгалан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Яах вэ, би тантай санал нэг байгаа юм. Энэ шинээр шинэчлэн батлуулахаар өргөн барьж байгаа Барилгын тухай хуульд яг энэ асуудлыг оруулахгүй бол хаа хаанаа хүндрэлтэй юм билээ. Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүртээмжийн асуудал биш. Энэ Монгол улс чинь бас газар нутгийн хувьд дэлхийд 17-д орж байгаа. Том газар нутагт. Увс аймгийн Хяргас суманд баригдаж байгаа сургуулийн барилга, соёлын төвийн, цэцэрлэгийн барилга 1 өөр геодезийн, газрын, хөрсний өөр ийм юутай. Тэгэхэд Дорнод аймгийн Дашбалбар суманд баригдаж байгаа бас тэр сургуулийн барилга, тэгээд Өмнөговь руу, Дундговь руу гээд бүгд өөр өөр байгаа. Тэгээд өнгөрсөн хугацаанд явж ирсэн энэ 1 маягийн зураг гэдэг асуудлыг бол бүсчилсэн, ядаж Монгол Улсын энэ том газар нутаг дээр бүсчилсэн хөгжлийнх нь чиглэлээр бас бид нар цаашдаа хийх ёстой юм байна. Нэг үгээр хэлбэл тэр орон нутаг, байгалийн, газрын, уул усны тогтоц, уур амьсгалд нь тааруулж энэ зургийг хийх ёстой. Ингэж байж чанартай, олон жил хэрэглэх, орчин үеийн чанар стандарт хангасан ийм барилга. Тэгээд энэ дотор нь мэдээж саяын таны ярьдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн асуудлыг цааш нь энэ барилгын хуулиа бид нар яг өргөн бариад, энэ хаврын чуулганаар болж өгвөл наадмаас өмнө батлаад ингээд явчихмаар байгаа юм. Тэгээд энэ дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, энэ олон нийтийн төлөөллийн төлөө дуу хоолойгоо өргөдөг гишүүд минь бас сайн оролцоорой. Энэ жижиг гэлтгүйгээр юмнууд нь орхигдчихдог юм. Ингээд хуулиа батлаад авсны дараа бол бид нар харин хяналтаа тавиад явахад боломж бололцоотой. Түрүүн Саранчулуун гишүүний хэлж байгаа зөвхөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, мөн нийслэл Улаанбаатар гээд яриад байхгүй. Тэр орон нутгийн засаг захиргааны нэгжийн Засаг дарга нар нь хүртэл энд хариуцлага хүлээдэг, үүрэг хүлээдэг, хяналт тавьдаг энэ механизмыг энэ барилгын хуулиуддаа бас оруулж өгөх нь зөв зүйтэй байх гэж ингэж бодож байгаа.

Дараагийн асуудал. Чингисийн өргөн чөлөө гээд та энэ Эрүүл мэнд, Гадаад яамнаас урагшаа томоохон гудамжийг хэлж байх шиг байна. Мэдээж энэ дотоод, гадаадын жуулчдын томоохон дэлгүүр шоппинг, худалдааны төвүүд, гаднынхан ч гэсэн зун цагаар ирдэг, хүүхдийн парк гээд л зөндөө явдаг гол зам байгаа. Тэгээд мэдээж манай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэд 20 минутын хот хөгжлийн төв ажиллаж байгаа. Тэгээд энэ хөгжлийн төв дээр бас их боломж бололцоонууд бас гардаг юм байна. Тэгэхдээ төсвийн мөнгөөр санхүүжилт байхгүй. Гэхдээ өөрснөө өнгөрсөн 1, 2 жилийн хугацаанд хийчихсэн жишээ нь, Япон

улсын олон төслүүдтэй хамтарч ажиллаж байгаа ийм төслүүд ... би 1 минут нэмээд авчихъя.

Л.Энхнасан: Нэмэлт 1 минут.

Э.Бат-Амгалан: Энэ төслүүд маань бол Улаанбаатар хотын хэмжээнд жишиг гудамж гэдэг юмыг хийж өгье. Тэнд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүртээмжийн асуудлаас эхлээд дугуй, скүүтер, ахмад настнууд, жирэмсэн эмэгтэйчүүд явах ийм боломж бололцоотой гээд ингээд болж байгаа юм. Хэрвээ таны цаг зав болдог бол манай энэ 20 минутын хот хөгжлийн төв дээр бас хамтарч ажиллаад, манайхаас бас ажлын хэсэг гаргаад хэдүүлээ бас жижигхэн, богинохон ч гэсэн энэ олны нүд тахалдаг энэ Чингисийн өргөн чөлөө, Их хааныхаа нэрээр нэрлэгдсэн энэ гудамжийг энэ төслийнхөнтэй холбож, хөрөнгө мөнгө, санхүү татах ажил дээр нь хамтран ажиллахад бол манай яам бэлэн байгаа. Нэгж ажиллаж байгаа. Мэдээж нийслэл Улаанбаатар хотын харьяалах тэр салбар нэгжийн удирдлагууд нь хамт ороод явах байх. Тэгээд таныг хэрвээ болно бүтнэ гэж үзэх юм бол энийг бас ажил болгоод хамтраад ажиллая гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Нөгөө орон сууцын фондын тухай асуусан. Энэ дээр хэн хариулах вэ. 5 дугаар микрофон.

О.Одбаяр: 2006 оноос 2013 он хүртэл бол нийслэл дээр орон сууц барьж байгаа иргэн, аж ахуйн нэгжээс 2 хувийг нь бол орон сууцын фонд бүрдүүлэх чиглэлээр Нийслэлийн иргэдийн Хурлын тогтоолтой авдаг байсан. Тэгээд тогтоолын хэрэгжилт нөгөө хуультай зөрчилдөж байна гэдэг үндэслэлээр орон сууцын фонд бүрдүүлэх ажил бол зогссон байгаа.

Дээрээс нь бол Улаанбаатар хотод 77км явган замын судалгааны ажил бол хийгдсэн. Энэ дээр бол бас зураг төслийн ажил нь бол 50 хувьтай явж байгаа гэдэг бас мэдээллийг өгчихье.

Д.Энхнасан: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Чингисийн өргөн чөлөө дээр яах вэ, жижиг юм боловч энэ өөрөө маш олон хүн хэн хийх юм бол гээд дунд нь үлдсэн л юм шиг байгаад байгаа юм. Тухайлбал хүүхдийн паркийн зүүн талд бол яг ингээд явган хүний тэргэнцэртэй, дугуйтай хүн явах тийм боломж нь байгаа байхгүй юу. Тийм учраас тэрийг л би хэлээд байгаа юм. Тэгэхээр удахгүй бас энэ дээр бол хамтраад ажиллая гэж бодож байна.

2 дугаарт энэ аваарын шат гээд байгаа юм. Аваарын шат дээр магадгүй явахад лифт бол ажиллахгүй болчихно. Аваарын заавар нь ийм байгаа. Тэр үед энэ хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай энэ хүмүүсийг яаж аврах вэ гэдэг ийм төлөвлөгөө өөрөө маш их чухал байгаад байгаа юм. Дэд бүтцийн хувьд бид нар бэлэн үү. Бид нарын аваарын шат чинь үндсэндээ бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулаагүй шатнууд ихэнх нь байгаад байгаа юм. Орон сууцууд, албан байгууллагууд, дэлгүүр хоршоо гээд энэ тал дээр та хэд маань бас нэг харж үзээрэй. Аюулгүй байдал гээд.

Тэгээд комисст бол тэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нь оруулчихсан нь зөв байх. Тэгээд 5 нь хаашаа юм зүгээр ямар ч байсан дор хаяж 2, 3 хүн бол байж байх л хэрэгтэй байх. Чиглэл чиглэлээрээ. Тэргэнцэртэй, хараагүй ч гэдэг юм уу,

сонсголгүй гэдэг юм уу энэ чиглэлийг нь бол тэд нар л илүү мэднэ гэдгийг хэлмээр байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Ганхүлэг гишүүн асуултаа асууна уу.

М.Ганхүлэг: Асуудал 2, 3 удаа бас Байнгын хороо дээр хэлэлцэхээр байж байгаад хойшлоод орж ирсэн. Яамнаас бас бэлдэж байгаа, асуултад хариулж байгаа материалууд бас нэлээн дутагдалтай санагдаад байна. Зүүн бүсийн аймгуудаар Саранчулуун гишүүнтэй хамт бас хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй нэлээн уулзаад, учраад ирсэн. Энэ хугацаанд бол ирсэн олон саналууд дээр тодорхой хуулийн төслүүд өргөн барих ажлууд дээр бас хамт оролцоод явж байгаа. Өнөөдөр яг энэ орон сууцтай холбогдолтой асуудал дээр сүүлийн 3 жилийн статистикийг гаргаж өгсөн байна. Тэгэхдээ Буянт-Ухаа 2, Хангай хотхон гээд аль 10 жилийн өмнө баригдсан хотхонуудад нийтдээ 61 хүн Улаанбаатарт олгосон гээд. Тэгээд яг энэ сүүлийн 3 жилд 61 юм уу, эсвэл энэ хотхонд үндсэндээ хамруулсан хүмүүс нь юм уу гэдэг дээрээ тодорхой болгоё.

Тэгээд бид нар нийтдээ бол хөдөө орон нутаг болон Улаанбаатарын түвшинд миний бодлоор сүүлийн 10 жилд бид нар 93 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд л энэ боломж олгосон ийм статистикийн тухай яриад байна уу. Цаашдаа ер нь бид нар яаж нэмэгдүүлэх юм бэ. Тэгээд бид нар хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм бий болгоно. Энэ нийгмийн бас иргэн болгондоо хүртээмжтэй ийм улс үндэстэн болно гээд ингээд зориод яваад байдаг. Гэхдээ яг бас бодит байдал дээр бас үндсэндээ Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй байхад байтугай эгэл жирийн хүмүүс ажиллах, амьдрах, алхах, явахад үндсэндээ хүртээмжгүй ийм л байдалтай байгаа асуудлын тухай үүний цаана бас яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ дээр ерөнхий тоон мэдээллүүдийг авъя. 740-өөр би бол хязгаарлагдахгүй болов уу гэж бодож байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орон сууцад орох энэ тоо судалгаа юмнуудаа яаж авсан юм. 2/3-ыг нь тэгээд ер нь яая гэсэн бодолтой, цаашдаа ямаршуу төлөвлөгөөтэй байгаа юм бэ.

Энэ 5 хувийг 10 хувь болгож байгаа нь бол зөв. OCD-ийн орнууд бол 6 орчим хувь. Зарим улс оронд бол 20-30 хувь энэ тэр гэж байдаг юм байна. Энийгээ бас өсгөөд явах нь бол зөв байх. 10 хувь болгосноороо ирээдүйд, ирэх 3 жил магадгүй хэчнээн хөгжлийн бэрхшээлтэй иргэд энэ боломжийг ашиглах боломж бүрдэх вэ. Хаана хандаж бүртгүүлэх вэ. Энэ 750 хүний бүртгэж байгаа тэр систем болон шалгаруулж байгаа тэр байдал нь өөрөө хүртээмжтэй байж чадаж байна уу гээд ингээд детальчлаад яривал нэлээн олон зүйлүүд бас байна.

Мөн дээрээс нь бид нар нийт баригдаж байгаа орон сууцынхаа 5 хувь, цаашдаа бол ингээд 10 хувийг ингээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан байдлаар хийх юм байна. Тухайн барилгыг бүхэлд нь бид нар хүртээмжтэй болгож чаддаггүй юм гэхэд тэр яг 6 хувьд нь тохирсон тэргэнцэртэй хүн ороход арай нэг лифтэнд өргөн байдаг юм уу, налуу зам байдаг юм уу тэр зүйлүүд нь бас хангагдсан. Нийт энэ байшин барилгынхаа тэр хувьдаа тааруулаад бас зохион байгуулалт хийх ийм дундын хувилбарууд бас байж болох уу. Одоо арга ядсан л ийм л санал л даа. Ер нь цаашдаа бид нар хүртээмжтэй байх чиглэлийн стандартыг бол барих ёстой. Яг хүртээмжтэй орон сууц барих энгийн хүмүүст зориулсан орон сууц барих 2-ын өртгийн .../минут дуусав/

Л.Энхнасан: Сайд хариулах уу. Бат-Амгалан сайд.

Э.Бат-Амгалан: Саранчулуун гишүүний асуулгад сүүлийн 3 жилд орон сууцжуулах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэд хэд орсон юм бэ гэдэг ийм яг хугацаа заасан асуулт явчихсан юм. Таны асууж байгаа асуулт яг зөв Ганхүлэг гишүүн ээ. Энэ 2015, 2016 оноос хойш энэ төрийн орон сууцыг хөлслүүлэх, борлуулах, түрээслэх журам хэрэгжиж эхэлснээс хойш явсан тоо баримт таны гар дээр байгаа шүү. Түүнээс сүүлийн 3 жилийн асуудал бол биш юм. 1 дүгээрт.

2 дугаарт энэ журам өөрчилснөөр би бас түрүүн гишүүний асуултад хариулж байхад хэлсэн. Журам өөрчлөгдсөнөөр цахимд шилжсэнээр бид нар аливаа нэгэн байгууллагын нэг дарга, удирдлага энэ эрх бүхий этгээд нь танил талдаа өгдөг энэ асуудлуудыг 1 дүгээрт таслан зогсоох, тэрийг дамжаад авлига, албан тушаал хардалт, сэрдэлтийн асуудлыг бас таслан зогсоох ийм давуу талтай. Сүүлийн 10 жилийн хугацаанд хийж хэрэгжээгүй гадуур хэл ам дагуулсан энэ асуудлыг энэ журмаараа бид нар бас амжилттай хийж чадсан гэж харж байгаа. Мэдээж бас алдаа оноо бол байгаа байх гэж ингэж бодож байна.

Энэ өртгийн асуудал яригдсан. Энэ Барилгын тухай хууль маань яг та бүхний оролцоотой, мэргэжлийн хүмүүсийн оролцоотой, жижиг гэлтгүйгээр шигтгэж оруулснаар, мөн дээрээс нь манай барилгын салбарт яг өнөөдрийн байдлаар 409 норм нормативын баримт бичиг ашиглагдаад явж байгаа. Энийг бид нар цаашдаа богино хугацаанд шинэчилж чадсанаар энэ хөгжлийн бэрхшээл, хүртээмжийн асуудлыг дараа хуульд, энэ норм дүрэмд хийж өгснөөс хяналт тавьж ажиллах ийм боломж, бололцоотой. Ер нь бол зүгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн амьдрах байр, зүгээр иргэний амьдрах байр гэж бол мэдээж тусдаа байхгүй. Энэ чинь дандаа л өнөөдөр байгаа хуульдаа, хууль, дүрэм журамдаа нийцүүлж уг нь шаардлагуудыг тавьж байгаа. Харамсалтай нь хяналт муу, сул байгаагаас энэ барилгуудыг хүлээгээд авчихдаг. Дараа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэнд байр худалдаж авч ороход асуудлууд үүсдэг ийм талууд байгаа гэдгийг бас хэлье.

Ер нь яг төрийн одоо өмчит орон сууц бол түрүүн бас ярианд хэлсэн. 2028 оныг болтол нийслэлийнхэн, манай барилгын яамныхан нийлээд 24 мянган орон сууц оруулна. Энэ журамд заасны дагуу ойролцоогоор 2400, тэрнээс 2000-2400 хөгжлийн бэрхшээлтэй иргэн орох боломжтой /минут дуусав/

Л.Энхнасан: Нэмэлт 1 минут.

Э.Бат-Амгалан: Түрүүн бас хэлсэн. Төсөл болгон өөр байгаа. Тийм учраас ер нь зүгээр дунджаар 2000 орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэд ирэх 3 жилийн хугацаанд баригдах, төрийн оролцоотой барьж байгаа 24 мянгаас 2 мянга орчим нь орох ийм боломж бололцоотой байгаа.

Л.Энхнасан: Гэрэл дарга хариулах уу. 1 дүгээр микрофон.

Д.Гэрэл: Асуултад хариулъя. Гэрэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар. Бид нар иргэдээс 2021 оноос хойш цаасан хэлбэрээр өргөдөл авч байгаа. Маш цөөхөн хэлбэр нь цахимаар өгч байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт нөгөө 2/3 нь ямархуу байдлаар орон сууцаар хангах вэ гэхээр сая Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дээр энэ асуудлыг тодорхой зохицуулсан байгаа. Өөрөөр хэлбэл нөгөө иргэдийнхээ орлогын түвшинд зохицуулж орон сууцаар хангах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай гэж үздэг. Өөрөөр хэлэх юм бол түрээс төлөх боломжтой хэсэг байхад, тэр 2/3 нь бол

ямар ч түрээс төлөх тийм орлогын эх үүсвэр хангалтгүй байгаа. Тэгэхээр энэ хүмүүст ямархуу байдлаар орон сууцаар хангах вэ гэхээр олон улсын жишиг бид нараас тавьж байгаа санал бол халамжийн орон сууц гэдэг зүйлээр энэ иргэдийг орон сууцжуулах. Халамжийн орон сууц гэдэг маань тухайн иргэний өмчлөлд өгөхгүй, зөвхөн амьд ахуй цагт нь тухайн байранд аюулгүй орчинд амьдрах боломжийг нь хангах байдлаар энэ асуудлыг бол олон улсад зохицуулдаг. Манай энэ зохицуулалт, энэ санаа ч гэсэн .../минут дуусав/

Л.Энхнасан: Ганхүлэг гишүүн тодруулга.

М.Ганхүлэг: Хариуцлагатайгаар бас ирэх 3 жилд 2400 орчим иргэдийг хамруулна гэдэг мэдэгдлийг сайд маань бас хэллээ. Орон нутгийн түвшинд энэ тоо ямар байх вэ. Энэ дээр байгаа судалгаа бол харин минийхээр бол сүүлийн бараг 10-аад жилд 93 хүний асуудлыг шийдсэн л харагдаад байгаа юм л даа. Тэгэхээр бид нар эндээ дүгнэлт хийхгүй бол бас болохгүй ийм нөхцөл байдлууд бас байна. Тэгээд 21 аймгаас бол 6, 7 аймаг дээр л түрээсийн орон сууцын ийм хөтөлбөрүүд бас хэрэгжиж байгаа юм байна. Тэгэхээр ер нь бусад аймгууд дээр яах вэ. Жишээлэх юм бол зүүн бүсийн хувьд зөвхөн Хэнтий аймаг л орсон байна. Тэгээд Дорнод, Сүхбаатарт байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бид нар яаж орон сууцжуулах вэ гэдэг дээр тодорхой бас хариулт авъя.

Дээрээс нь хэрвээ барилгын салбарынхан маань байвал өртгийн хувьд яг ямар зөрүү гардаг юм бэ. Яг анх баригдах өртөг нь тодорхой хувиар мэдээжийн хэрэг нэмэгдэх байх. Тэгэхээр тэр дээр тооцоо судалгаа энэ тэр юмнууд байна уу. Эдгээрийн хариултыг авъя.

Л.Энхнасан: Сайд хариулна уу.

Э.Бат-Амгалан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Таны асууж байгаа асуулт яг зөв. Саяын ярьдаг 24 мянга гэдэг бол нийслэл Улаанбаатар хотод байгаа. Бусад 21 аймгийн төвүүдэд бид нар бас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсчлээд, тэгээд таталцлынхаар нь, сумаар нь, аймгаар нь ингээд төлөвлөлтүүд гаргаж байгаа. Хамгийн гол асуудал бол зөвхөн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам гэхгүйгээр аймаг, орон нутгийн удирдлагууд хамтарч ажиллах ийм гол юм байгаа. Бид нар зөвхөн нь өнөөдөр Барилгын тухай хууль өргөн барихаас гадна Хот байгуулалтын тухай хуулиа өргөн барьж байгаа. Энэ хаврын чуулганаар Орон сууцжуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын банкны тухай хууль барьж байгаа. Тэгээд ер нь аливаа юмны үндсийн үндэс нь бол суурь фундамент нь байдаг учраас энэ Хот байгуулалтын хуулиа өргөн барина. Тэгээд аймаг, орон нутгийн удирдлагууд энэ дээр хот байгуулалтынхаа өөрийнхөө аймаг, орон нутагт таарсан хөгжлийн шинэ загвар, зураглалаа, ерөнхий төлөвлөгөөгөө хийх ёстой.../минут дуусав/

Л.Энхнасан: Өртөг яг яаж нэмэгдэж байгаа юм. Ажлын хэсгээс хариулах уу. 5 дугаар микрофон.

О.Одбаяр: Яах вэ, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд яг зориулсан орон сууц гэх юм бол бас тэр Японы жишгээр бол бас тусдаа халамжийн орон сууц гэдэг хөтөлбөр явдаг юм байна лээ. Тэр дээр бол ер нь барилгын өртөг бол Япондоо бол өндөр байгаа. Бид бол тодорхой хэмжээнд түрүүчийн гишүүний хэлдгээр явган зам тохижилт, шатны бас тодорхой хэмжээний тоноглол, тэгээд 00-ийн суултуур, бусад

гадна тохижилтуудыг хийхэд 10-20 хувиар бол метр квадратын үнэ нь бол нэмэгдэх юм байна лээ.

Л.Энхнасан: Тодруулга Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Тийм бусад улс, зарим орнуудад бас нэг ийм жишгүүд байдаг юм байна. Одоо байгаа энгийн байрыг хүртээмжтэй болгоход зориулсан ийм тусдаа үйлчилгээнүүд бас байдаг юм байна. Тэр одоо зээлээр байдаг юм уу, тодорхой хөнгөлөлттэй нөхцөлөөр. Тэгэхээр яах вэ, ийм хувилбар юмнуудыг бас тооцож судалж байгаа зүйлүүд байна уу. Бас ийм төрлийн бас үйлчилгээг авахыг хүсэж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэд бас хэр их байдаг вэ. Ийм тохируулгууд өөрсдөө хийдэг онцлогууд бас байна.

Л.Энхнасан: Ажлын хэсэг хариулах уу. 5 дугаар микрофон.

О.Одбаяр: Бид нар бол Орон сууцжуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын банкны тухай анхдагч хуулийн төсөл санаачлаад явж байгаа. Энэ дээр бол нийгмийн халамжийг сайжруулах, хүртээмжтэй байх хүрээнд бол тодорхой хэмжээний халамжийн орон сууцуудыг орон сууцын хорооллын түвшинд нь бол хийе. Ер нь Монголын нөхцөлд бол яг тусад нь зориулсан барилга байгууламж бол байхгүй. Тэгэхээр бид энэ туршлагыг судалж, барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахаар бас тодорхой судалгаа хийгээд ажиллаж байгаа.

Орон сууцжуулалтын тухай хууль дээр бол бас орон сууцын төлбөрөө төлж чадахгүй иргэдэд бас Монголбанкны Ерөнхийлөгчийн гаргасан өр орлогын харьцаа бол 45 хувиас бага тохиолдолд салбарын тэр нийгмийн халамж хариуцсан яам болон аймаг, орон нутгийн засаг дарга нарын .../минут дуусав/

Л.Энхнасан: Гүйцээж хариулна уу. 5 дугаар микрофон.

О.Одбаяр: Тэгээд 45 хувиас буусан тохиолдолд тодорхой хэмжээний нийгмийн халамжийн яам, орон нутгийн засаг дарга нарт улсын төсөв дээр бол мөнгийг нь суулгаж энэ төлбөрийн асуудлыг бол бас шийдвэрлэх боломжтой гэж бид нар харж байгаа. Тэгээд хуулийн төсөл дээрээ бас энэ бүлгийг бол оруулж өгч байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Галбадрах гишүүн асуултаа асууна уу.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе. Их чухал асуудал яригдаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцын асуудал бас яригдаж байгаатай зэрэгцээд бас сургуулиудын асуудлыг бас та бүхэнд хандана гэж ингэж бодож байна. Сургуулиудад бас энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах тал, орчны асуудал бол бас нэлээн чухлаар яригдаж байгаа.

Миний асуулт бол ер нь Улаанбаатар хотод шинээр ч их олон орон сууц баригдаж байна. Тэр юун дотор хэдэн хувь нь яг 100 хувь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд энэ шаардлагад нь нийцсэн байдаг вэ. Ялангуяа сүүлийн 3 жил бид нар яриад байна шүү дээ. Сүүлийн 3 жилд баригдсан нийт орон сууцын дотор яг 100 хувь энийг ингээд шаардлага хангачихсан. Тэгээд 80 хүртэл хувь нь хангасан ч гэдэг юм уу, 60 хүртэл хувь нь ч гэдэг юм уу ийм хангасан орон сууц нь ер нь хэр баригдаж байгаа вэ. Би асууж байгаа нь бол ашиглалтад авах үед бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл орж ирдэг. Бүр тэргэнцэртэй хүн ч гэсэн өөрөө ингээд оччихсон,

өөрөө явж үзээд бүр ингээд авч байдаг шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар ямар бэрхшээлүүд зөрчлүүд илэрдэг юм бол. Тэгээд энэ нь одоо ямар түвшинд нь засаж болох тийм зөрчлүүд байдаг уу. Энэ талаар ер нь ямар юм байдаг вэ. Тэр комисст орж байгаа төлөөллийг хэрхэн сонгодог вэ.

Ер нь бол ингээд барилгын зургийн л эхэн үе шатаас л гарна л даа. Тэгэхээр тэрийг Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөний газар энэ тэр баталдаг шүү дээ. Манай яам хэрхэн оролцдог юм байгаа юм. Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань яаж оролцдог юм. Тэр зураг дээр Барилга хөгжлийн төв гээд байдаг. Энэ зургийн шатад нь хэр та нар маань бас ажилладаг вэ гэдэг асуудал.

Тэгээд миний асууж байгаа нь бас тэгээд хэр засдаг вэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл ороод хэлсний үр дүн тэр хэр засагддаг вэ гэдгийг асуучихъя.

Мөн зүгээр сургуулийн хувьд бол тэр Өмнөговийн Даланзадгад хотод байдаг 5 дугаар сургууль бол лифттэй тийм жишиг сургууль болчихсон байсан. Тэгэхээр ийм лифт дараа нь хийчихсэн байсан л даа. Ийм маягаар сургуулиуд дотор лифттэй сургууль байдаг уу. Орон сууцад ч мэдээж энэ 5 давхрын барилгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хуучин барилга энэ тэрд ороход ямар юм байдаг юм бэ гэдгийг. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэр нөхцөл хийхийн тулд тэр СӨХ-ийн төлбөр энэ тэрд нь бас оруулдаг ийм зүйлүүд журам энэ тэр бас байдаг уу. Ер нь хамгийн их асуумаар байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгон шалгаруулж орон сууцад оруулахад ер нь тэр журам нь нээлттэй байдаг уу. Зарлал нь яаж явдаг вэ. Ямар өргөдөл, хүсэлт хүлээж авдаг вэ. Хэрхэн шалгаруулдаг вэ. Тэгээд тэр шалгаруулалт нь ийм тусгай журам байдаг уу.

Өөр бас нэг асуух юм нь ипотекийн зээлтэйгээ хэр уялдсан байдаг юм вэ. Ипотекийн зээлтэй уялдаж байж л орон сууц бас худалдаж авах боломж нь нээгддэг. Тэгэхээр энэ дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусгай заалт бий юу гэдгийг бас асууя.

Л.Энхнасан: Ажлын хэсэг 5 дугаар микрофон уу. 6 дугаар микрофон. Дараа нь 8 дугаар микрофон хариулах юм байна.

М.Баяраа: Тоон дээр нэмэлтээр манайхаас хариулт өгнө. Зургийн шатад бол оролцоод явж байгаа. Өнгөрсөн хугацаанд бол нийт барилга байгууламжийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх гээд 350122 гээд барилгын норм дүрмийн дагуу орон тооны бус экспертүүд бол 1367 барилга байгууламж дээр хяналтыг тавьж ажилласан байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг барилга хүлээж авах комисс дээр бол ажиллаад явж байгаа. Сүүлийн үед яах вэ, манай яг салбарын дэд комисс дээр бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө комисс дээр ормоор байна. Яг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төлөөлж байгаа төрийн байгууллагууд нь комисст ороод байна гэдэг өргөдөл гэх юм уу, гомдол мэдүүлсэн. Тэгэхээр энэ тал дээр бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийг яг энэ комисст оруулах тал дээр бас цаашдаа арга хэмжээ авч ажиллана гээд төлөвлөж байна.

Ипотекийн зээлтэй холбоотой асуудал болохоор ер нь одоогийн 6 хувийн бидний боловсруулж байгаа энэ орон сууц бол Орон сууцжуулалт, орон сууцжуулалтын банкны тухай хууль дээр бол ер нь ипотекийн зээлийг төрөлжүүлэх асуудал яригдаж байгаа юм. 6 хувийн зээлийг бол ямар ч орлоготой хүн аваад байгаа. Тэрийг бол өөрөө энэ улсын татаасаар ирж байгаа учраас энийг яг зорилтот бүлэгтээ энэ 6 хувиа зарцуулдаг байя. Тодорхой орлоготой залуу юм уу, гэр

бүлүүдэд 10-12 хувийг тэр орон сууцжуулалтын банкаараа дамжуулаад, бонд босгох замаар эх үүсвэрийг бий болгоё гэдэг ч юм уу. Бусад нь болохоор арилжааны банкаар авагдаж байгаа зарим нэгэн өндөр зээлийг аваад явах боломжтой айлууд ч байгаа гээд. Тэгэхээр энийгээ бол төрөлжүүлж өгье гэдэг ийм бодлого ипотек дээр баримтлаад ингээд явж байгаа.

Л.Энхнасан: 8 дугаар микрофон. Дараа нь Гэрэл дарга бас хариульъя гэсэн. 1 дүгээр микрофон.

Б.Мөнхтөр: Ер нь бол барилга байгууламжийг ашиглалтад авах үйл ажиллагаанд бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах асуудлыг бол түрүүн тоо хэмжээг нь хэлсэн. Зураг төсөл талаасаа мөн тоо хэмжээг бол хэлсэн байгаа. Магадлал хийх талаасаа бас Төрийн нарийн бичгийн дарга сая нэлээн тодорхой тоонууд хэлчихлээ. Зүгээр квотын хувьд бол ер нь улсын хэмжээнд цэцэрлэг, сургууль, ногоон байгууламж, автомашины зогсоол болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ техникийн шаардлагыг хангасан энэ хувь хэмжээ бол сургууль цэцэрлэгийн хэмжээнд бол 40 орчим хувьтай байна. Энийг бол цаашдаа нэмэгдүүлэх албан даалгаврыг бол сайдын зүгээс 21 аймаг, нийслэл гээд бүх газруудад бол хүргүүлчихсэн байгаа. Бид нарын зүгээс бол хэрэгжилтийг хяналт тавьж бол ажиллана. Өөр энэ квот тоог бол нэмэгдүүлэх ийм арга хэмжээг бол тогтмол авч явна гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Энхнасан: 1 дүгээр микрофон.

Д.Гэрэл: Барилгын комисст хэрхэн орж байна вэ гэхээр ер нь Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хараагүйчүүдийн үндэсний холбооны төлөөллүүдийг бол нийслэл Улаанбаатар хотод комисст оруулах талаар бол сүүлийн 10 жил хамтраад явж байгаа. Мөн манай агентлаг руу хандаж тодорхой барилгыг хүлээж авах тохиолдолд төлөөлж оролцох хүмүүсийн нэрсийг авдаг. Бид нар цаашдаа энэ яг барилгын комисст ороод явахад ямар бэрхшээл тулгарч байна вэ гэхээр жишээлэх юм бол нөгөө 1 маягийн зургаар өрхийн эмнэлэг баригдах тохиолдол байдаг. 3 давхар сургууль баригдахад лифт хийгдээгүй, анхнаасаа зураг дээрээ тусгагдаагүй гэх мэт асуудлууд гардаг. Энэ дээр бол шаардлага хүргүүлэхэд хэрэгжих боломжгүй. Бусад тохиолдолд шаардлага өгөөд бас тодорхой сайжруулалтыг бол хийгээд явдаг байгаа. Одоо энэ комисст орж ажиллах хүмүүсийн чадвар чадавхыг сайжруулахын тулд агентлагийн зүгээс тодорхой сургалтын модуль хөтөлбөр гаргаад яг энэ комисст орж ажиллах хүмүүсийг илүү чадавхжуулж мэргэшүүлэх бусад аймаг, орон нутагт байгаа хүмүүсийгээ бас чадавхжуулах энэ ажлыг яг хийгээд, эхлээд явж байгаа. Цаашдаа энэ .../минут дуусав/

Л.Энхнасан: Шалгаруулалт. Яаж хүмүүсээ сонгон шалгаруулдаг юм. Хаана ханддаг юм. 1 дүгээр микрофон.

Д.Гэрэл: Одоо бол энэ төрийн бус байгууллагуудтай анх сонгож байхдаа хамтарч ажиллаад яг энэ чиглэлээр мэргэшсэн үнэлгээ хийдэг энэ төрийн бус байгууллагуудтай хамтраад төлөөллийг нь оролцуулаад, сургалтад хамруулаад явж байсан. Одоо бид нар харин энэ шалгаруулалтыг илүү боловсронгуй болгох үүднээс сургалтад хамруулаад, магадлаад, тэнцсэн хүмүүсээ оролцуулахаар ингээд чиглээд явж байгаа.

Л.Энхнасан: Галбадрах гишүүн тодруулга авах уу. Тодруулга.

Ж.Галбадрах: Тэгээд миний асуугаад байгаа нь Буянт-Ухаа 2 хороолол баригдлаа. Тэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн одоо бид нар 5-10 хувь гээд ингээд зааж байгаа бол энд орох боломжтой гэж зарлаад хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэр зарыг нь хараад, өргөдлөө өгөөд ингээд ямар нээлттэйгээр шалгаруулалтад орох боломжтой вэ гэдгийг би асуугаад байгаа юм. Тэрнээс гадна орон сууцын гадаа сая бас ярьж байна. Тэгээд зогсоолууд байдаг. Гэтэл яг одоо орон сууцын гадаа хөгжлийн бэрхшээлтэй иргэний машин тавих зогсоол гээд ингээд тусгай гаргадаг тэр шаардлага энэ тэрийг хангадаг ч гэдэг юм уу ийм нарийн ийм шаардлагуудыг бас хэр тавьж явдаг юм гэдгийг бас асуучихъя. Энэ бол ихэнх байранд л байхгүй байгаад байгаа. Гэтэл одоо энийгээ гаргаж ирж байж явах, тэр лифт рүү хаалгаар ороод ирэхэд гадна талынх нь бол ийм тэргэнцэртэй хүн ороод ирэх байдаг. Орж ирэнгүүт ахиад ийм шатны гишгүүр дотор талд нь байж байдаг. Тэгээд лифт рүүгээ орох хүртэл нэлээн зам, лифтнээс буугаад гэр лүүгээ орох хүртэл бас ахиад шатны гишгүүр гараад ирчихсэн ч байж байдаг юм уу ийм юмнууд .../минут дуусав/

Л.Энхнасан: 8 дугаар микрофон хариулах уу. Одбаяр дарга хариулах уу. 5 дугаар микрофон.

О.Одбаяр: Зураг төсөл дээр бол манайх магадлал хийх нөгөө чек лист гэж байгаа. Энэ дээр бол тэр хүснэгт болгон дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн норм дүрмийг хангасан байдал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг нэмэгдүүлсэн байдал дээр бол зураг төсөл хийж байгаа магадлалын экспертүүд бол бүгд дээр нь чек лист хийж байгаа. Саяын тэр сүүлийн үеийн барилгууд дээр бол гадна талаасаа пандусаар орно. Дотор талдаа шаттай байх, энэ шатны маршийг бид нар бол аль болохоор хасахаар зураг төсөл дээрээ голчилж ажиллаж байгаа.

Шалгаруулалт хэрхэн явдаг вэ гээд. Саяын энэ түрүүчийн ярьсан орон сууц, төрийн орон сууцыг өмчлөх, түрээслэх журам дээр бол Төрийн орон сууцын корпорац бол энэ шалгаруулалтыг зохион байгуулна. Ер нь бол цахимаар бүгдийг бол зохион байгуулна гэсэн. Энэ дээр нэмээд бол яг хөгжлийн бэрхшээлтэй гарцаагүй энэ шаардлагатай иргэдийг бас цаасан байдлаар хүсэлтийг бол хүлээж авах боломжтой.../минут дуусав/

Л.Энхнасан: 5 дугаар микрофон нэмэлт.

О.Одбаяр: Хот байгуулалтын норм дүрэм 300104 гэж норм байдаг. Энэ болохоор 2004 онд батлагдсанаас хойш бол сайжруулалт хийгээгүй явж байгаа норм. Одоо бол бид бүгд норм дүрмээ бол боловсруулчихсан. Энэ дээр бол 1 айл 1 машины зогсоолтой гэдэг энэ хувилбарыг бол бид нар оруулж ирж байгаа. Хуучин ер нь бол 1 орон сууцын гадаа 30 хувь нь зам талбай, ногоон байгууламж байна гэдгийг одоо бид нар норм дүрмээрээ энийг шийдэж байгаа. 1 айл 1 машинтай. Тэр машины зогсоолууд дотроос бол яг хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хэдэн хувийг нь хангасан байх юм гэдэг зохицуулалтыг бол бас энэ норм дээр оруулж ирж байгаа. Тийм учраас бол гадна машины зогсоол, дээрээс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэр хүртээмжийг нь нэмэгдүүлэх чиглэлийн шийдлүүдийг бол хот байгуулалтын норм дүрэм дээр бол суулгасан.

Л.Энхнасан: Баярлалаа. Алтаншагай гишүүн асуултаа асууна уу.

Н.Алтаншагай: Баярлалаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар, хүртээмжийн талаар яривал маш олон зүйл, олон сэдвүүд яригдана. Өнөөдөр бол энэ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон сууцжуулах талаар асуудал хэлэлцэгдэж

байна гэж ойлгож байна. Тэгээд Саранчулуун гишүүндээ баярлалаа. Маш чухал асуудлууд хөндөгдөж байгаа, асууж бас тодруулж байгаад талархал илэрхийлье.

Монгол Улсад 107 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй хүн байна гэж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 94 мянган өрх байна. 94 мянган өрхийн 44 хувь нь гэрт, 34,4 хувь нь байшинд, 0,9 хувь нь л орон сууц, нийтийн байранд байна гэсэн ийм тоон судалгаа байна. Энэ их олон өнцгөөс яригддаг зүйл. Тэгээд хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэр бүл байна. Энэ нөгөө байр орон сууц руу шилжих энэ асуудлууд их хурцаар яригддаг, хүндээр яригддаг. Яг бодит бид бүхэнд бол энэ хууль тогтоомж дээр заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тухайлан заагдсан яг ийм заалт байна уу. Ийм байранд ороход ийм хөнгөлөлт үзүүлнэ, ийм ийм шаардлага, шалгуур байна гэж. Энийгээ бид бүхэн яг хэрэгжүүлж чадахгүй л байгаа юм.

Хүртээмжтэй асуудлуудыг маш их ярьж байна. Яг нөгөө комисст нь орох уу л гэж байна. Зураг төсөлд нь орох уу л гэж байна. Тэр дүүргүүд дээр бол уг нь ороод л явдаг. Болдог юм шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийхээ төлөөллийг тэр комисст нь ажиллуулаад болж л байсан. Шийдвэрүүд гарч л байсан. Тэгэхээр энийгээ бас сайжруулах тал дээр төвлөрүүлэх биш энэ орон нутаг руу нь эрхийг нь өгөөч ээ гэж. Энэ асуудлаар.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар гэж байгаа юм. Яг энэ дээр ангилсан тийм яг судалгаа байна уу. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн яг энэ орон сууцад оръё гээд харааны бэрхшээлтэй, тулгуур эрхтний бэрхшээлтэй, сэтгэцийн гээд маш олон бас төрлийн хэлбэрүүдтэй байгаа шүү дээ. Яг энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа байна уу. Цахим руу энэ байранд оръё гэсэн хүсэлтийг, орон сууцад оръё гэсэн хүсэлтийг цахим руу шилжүүлж цахим руу нааж болохгүй. Түрүүн Баясгалан гишүүн хэлж байна лээ. Цахим дээр ажиллаж чадахгүй маш олон хүн байгаа шүү. Тэгэхээр энийг яг энэ дүүрэг, хорооноос нь нарийвчилж аваад, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар маань өөр дээрээ төвлөрүүлээд энэ БХБЯ энэ холбогдох НОСК, ТОСК руу нь өгөөд, энэ хүсэлтийг нь нээлттэй болгомоор байгаа юм. Тэгээд төр өөрөө энэ дээр бас онцгойлон анхаарч бодит дэмжлэгийг үзүүлж, санхүү дээр нь дэмжлэгийг үзүүлэх хэрэгтэй. Түрээслээд өмчлөх орон сууц авчихсан ийм ээж байсан. Хүүхэдтэйгээ хоёулаа амьдардаг. Төлбөрөө төлж чадахгүй байрнаасаа хөөгдөөд явж байсан. /минут дуусав/

Л.Энхнасан: Нэмэлт 1 минут.

Н.Алтаншагай: Сонгинохайрхан дүүрэгт бодит 1 жишээ байгаа шүү дээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй байдаг. Хөөцөлдөж байгаад түрээслээд өмчлөх орон сууц авчихсан. 100 хувь хүүхэд нь асаргаанд байдаг. Тэгээд нөгөө байрныхаа түрээсийг төлж чадахгүй сүүлдээ ингээд байрнаас нь хөөгөөд НОСК-оос бичиг ирчихсэн. Байраа чөлөөлж өг гээд ийм хүндрэлтэй нөхцөл байдал яг нүдэн дээр, гар дээр үүсчихсэн л байсан. Бид бүхэн холбогдох бүх байгууллагууд руу нь хүсэлтийг нь өгсөн. Тэгээд ер нь удаашралтай. Тэр шийдвэрлэгдэж чадаагүй шүү. Тэгэхээр яг ийм хүмүүстээ энэ төр маань анхаарах ёстой. Энэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газар маань өөрөө бодлогоо гаргаж, уялдуулах хэрэгтэй. Дараа нь тодруулъя.

Л.Энхнасан: 1 дүгээр микрофон Гэрэл дарга хариулна уу.

Д.Гэрэл: 1 дүгээрт яг 2021 оноос иргэдээс яг тухайн үед бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон сууцжуулах хөтөлбөр гэдгийг 2 жилийн хугацаанд боловсруулж байсан. Үүнтэй холбогдуулаад манай агентлаг дээр иргэдээс өргөдөл авах тухай асуудал гараад, бид нар тэр үеэс иргэдээс өргөдөл хүлээж авч, иргэдийн өргөдлийг нэгтгэж эхэлсэн. Энэ иргэдийн хүрээнд бол бид нар яг статистик мэдээллээр бол 7 чиглэлд ангилж үздэг байгаа. Энэ чиглэлээр бол мэдээлэл гарч байгаа. Гэхдээ түрүүний дурдсан шиг энэ бол зөвхөн нийслэл Улаанбаатар хотод мэдээлэлтэй байгаа хүмүүс манайд өргөдлөө өгсөн. Энэ дээр өргөдлөө өгч чадаагүй иргэд бол нэлээн байгаа гэж бид нар бол харж байгаа.

Тэгээд 2 дугаарт нь энэ хүрээнд бид нар ямар бодлого барьж байна вэ гэхээр нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдралын түвшин, орлогын нөхцөлтэй уялдуулсан байдлаар орон сууцаар хангах хөтөлбөр байх ёстой гэдэг үүднээс бид нар удаа дараа бодлогоо гаргаж явдаг. Энэ чиглэлээр бол ипотекийн орон сууц, түрээсийн орон сууц, тэгээд халамжийн орон сууц, дээрээс нь хашаа байшинд амьдарч байгаа хүмүүсийн орчныг сайжруулах гэсэн энэ 4 чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих ёстой юм гэдэг үүднээс саналаа боловсруулж хэрэглэдэг. Үүний хүрээнд ч энэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.2 дээр энэ үзэл санаа маань туссан байгаа.

Тэгээд өнөөдөр бол энэ түрээсийн орон сууцын журам гарч байгаа нь энэ чиглэлийн нэг хэсэгт нь 10 хувийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдах боломж нээгдэж байгаа гэж үзэж байгаа. Одоо бид нарын хийж байгаа ажил бол энэ түрээсийн орон сууцад хамрагдах иргэдэд дотор нь бас ямар шалгуур тавих вэ гэдэг асуудал дээр санал боловсруулаад, яамаараа дамжуулаад БХБЯ-нд хүргүүлэхээр одоогийн байдлаар бол ажиллаж байгаа.

Л.Энхнасан: Тодруулга Алтаншагай гишүүн.

Н.Алтаншагай: Түрүүн би асуусан даа. Яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тухайлан заасан яг тийм бодлогын заалт байгаа юу гээд. БХБЯ-ныхан хариулах юм уу. Хөгжлийн бэрхшээлтэй юуныхан яах юм уу. Дээр нь тэр хүртээмжтэй холбоотой асуудлыг бас түрүүн олон гишүүд ярьж байна. Яг сургууль, цэцэрлэгийн орчин гээд ярих юм бол маш хүндрэлтэй нөхцөл байдалтай байгаа. Яг тухайлсан сургууль барина, цэцэрлэг барина гэхээр бас зарим эх эцэг эхчүүд нь дургүйлхдэг. Сонгинохайрхан дүүрэгт бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг баригдсан. Сургуулийн асуудал ингээд яригдаад явж байгаа. Зарим эцэг эхчүүд төвлөрүүлэх шаардлагагүй гээд ингээд уурладаг. Одоо яг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд авч байгаа сургуулиуд бас багш нар бас яг хүндрэлтэй нөхцөл байдал байдаг шүү. Сургуулийн орчин, хэрэглэгдэхүүн гээд маш хүндрэлтэй асуудал байдаг. Тэгэхээр энэ дээр бас тухайлан яг ямар бодлого цаашдаа барьж явах юм бэ гэдгийг тодруулъя.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 1 дүгээр микрофон Гэрэл дарга.

Д.Гэрэл: Тодруулга хийе. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар Гэрэл. Яг би түрүүн хэлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 25.2 дээр энэ суурь заалт маань байдаг. Энэ хуулийн заалтыг хэрэгжүүлэх хөтөлбөр байна гээд хууль дээр минь заачихсан байдаг. Яг энэ 4 орон сууцаар хэрхэн хангах асуудлыг зохицуулсан цогц хөтөлбөр бол байхгүй. Зөвхөн энэ түрээслэх болон түрээслээд өмчлөх энэ орон сууцын журамд 10 хувийг олгоно гэдэг зохицуулалт бол явж байгаа. Бусад ипотека, халамж, амины орон сууц, гэр

хорооллын нөхцөлийг яаж сайжруулах вэ гэдэг дээр бол нэгдсэн бодлого яг төлөвлөлт бол өнөөдөр байхгүй байгаа.

Л.Энхнасан: 8 дугаар микрофон Мөнхтөр дарга хариулна уу.

Б.Мөнхтөр: Алтаншагайн гишүүний асуултад аль болох бүрэн дүүрэн хариулахыг бодъё. Ер нь бол төлөвлөлт талаасаа бас бид нарт тулгарч байгаа 1 асуудал бол газрын асуудал байдаг. Хэдийгээр бид нар төлөвлөлт, зураг төсөл, магадлалыг зөв хийсэн ч гэсэн газар олголтод очоод төлөвлөлт өөрчлөгдөх энэ асуудлууд байгаа. Тэр болгон бас хүртээмжтэй зай талбай дүүргүүд дээр байдаггүй. Иймэрхүү бэрхшээлүүд бас нэлээн гарч байгаа. Нөгөөтээгүүр ер нь бас асууж байсан. Өмнөх салбарын хууль тогтоомжуудад бол ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчныг бол ерөнхийдөө норм, дүрэм журам, стандартыг хангуулах талаас нэлээн түлхүү сууж өгсөн байдаг. Одоогийн бид нарын боловсруулж байгаа Орон сууцжуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын банкны тухай хууль энэ тэрт бол ер нь аль болох зорилтот бүлгийг орон сууцаар хангах, түүний эрх зүйн орчныг яаж зөв бүрдүүлэх вэ, боломжуудыг бүрдүүлэх талаас нь илүү асуудалд хандаж явж байгаа. Ерөнхийдөө гол зохицуулалт гэвэл бид нар ерөнхийдөө метр квадратыг нь зааж, квотын хэмжээг зааж өгөх. Энэ асуудлыг аль хурдхан шийдэх вэ гээд эрх зүйн орчныг аль болох иргэд рүүгээ чиглэсэн маягаар эрх зүйн орчнуудыг бол бас хуульд .../минут дуусав/

Л.Энхнасан: 8 дугаар микрофон нэмэлт минут.

Б.Мөнхтөр: Нөгөөтээгүүр хэдийгээр хууль батлагдлаа гэж бодоход бас энэ асуудал бүрэн дүүрэн шийдэгдчихнэ гэж бид нар бол хэлж болохгүй. Цаашдаа ер нь хөрөнгө бол санхүүжилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж явах юм. Төсөв суулгаж явах юм уу, тодорхой төрийн захиргааны төв байгууллага нь энэ асуудлаа жил жилийн төсвийг нь шийдээд явах уу энэ тэр гээд дараа дараагийн харилцаанууд бас бид нарт зайлшгүй шийдвэрлэх асуудал болоод үлдэж байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Нөгөөтээгүүр бас төлөвлөлт дээрээ эргэж нэг тодруулахад ер нь бол дан ганцаараа юу гэдэг юм хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ зориулсан орон сууц бариад явна гэвэл бас харьцангуй өрөөсгөл. Ерөнхийдөө бол нийгэмшлийн хувьд бол хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань эрүүл хүмүүстэй хамт байж байвал энэ нь өөрөө нийгэмшил, төлөвшил талаасаа зөв байдаг. Тэгэхээр бол цаашдаа ч гэсэн тусгаарлахгүйгээр хамтад нь шийдвэрлэгдээд явна гэдгийг та бүхэнд хэлэх байна. Баярлалаа.

Л.Энхнасан: Баярлалаа. Хосбаяр гишүүн асуултаа асууна.

Г.Хосбаяр: Энэ нийгмийн бас зорилтот хэсгээ орон сууцжуулах асуудал бол чухал байгаа. Одоо хөдөө орон нутагт байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ч асуудал байна. Мөн эмч, багш нарыг орон сууцжуулах асуудал гээд л ингээд л салбар салбар төрөл бүрийн л ийм асуудлууд үүсэж байгаа. Тэгээд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамныхан Барилгын тухай хуулиа өргөн барьж байгаа гэж ярилаа. Энэ уг нь ноднин л яригдаад байсан. Тэгээд яаралтай өргөн бариад хэлэлцүүлмээр байна. Би өөрөө бас 10 гаруй жил барилгын салбарт, хувийн хэвшилд ажиллаж байсан хүн. Ер нь бол Барилгын тухай ерөнхий хуулийг бол шинэчлэх зайлшгүй шаардлага үүсчихсэн. Монгол Улсад өнөөдөр хэрэглэгдэж байгаа барилгын норм дүрмүүд бас шинэчлэх шаардлага үүсчихсэн. Тэгээд энэ барилгын тухай хуулиа шинэчлэхгүй, норм дүрмээ шинэчлэхгүйгээс чинь болоод л энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх хангагдахгүй байна. Явган зам талбай ч

гэдэг юм уу энэ барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй биш байна гэдэг ийм асуудлууд чинь үүсээд байгаа юм. Тийм учраас энэ барилгын тухай хуулиа яаралтай өргөн бариад, тэр мэргэжлийн холбоодын саналыг аваад, мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо төрийн бус байгууллагуудын саналыг аваад ингээд олигтойхон шиг чамбай хууль Их Хурлаар батлуулах шаардлагатай байна гэдэг ийм зүйлийг хэлье. Тэгээд энэ дээрээ яг сайн ажиллаж байгаа юу гэдэгт бас хариулт хэлээрэй.

2 дугаарт нь бол орон сууцжуулах асуудал бол ганц танай яамны буюу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны асуудал биш байх л даа. Тэгэхтэйгээ зэрэг энэ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, мөн Засгийн газартайгаа сайн яриад тэр Орон сууцжуулалтын банкны тухай хуулиа бас сайн боловсруулж орж ирэх хэрэг байна. Тэгэхгүй бол одоо зүгээр ганцхан Орон сууцжуулалтын яам энэ иргэдийг орон сууцжуулах асуудал гэж бас ойлгож болохгүй л дээ. Тэгэхээр яг тэр Орон сууцжуулалтын банкны тухай хууль дээр чинь яг энэ нийгмийн зорилтот бүлэгтээ чиглэсэн ямар зүйл заалт, ямар бодлого байгаа юм бэ. Одоогоор яригдаж байгаа. Тэрийг бас тодруулж хэлж өгөөч гэсэн ийм 2 асуулт байна. Барилгын тухай хууль, санхүүжилт. Орон сууцжуулалтын банкны тухай гээд.

Л.Энхнасан: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. 6 дугаар микрофон.

М.Баяраа: Яамнаас санаачлаад Засгийн газарт өргөн барихаар бэлдээд явж байгаа 4 хууль байгаа. Орон сууцжуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын банкны тухай хууль гээд. Саяын таны дурдсан Орон сууцжуулалтын банкны тухай хууль бол цогц хуулиар оруулж байгаа юм. Өмнө нь бол Үндэсний орон сууцжуулалтын тухай хууль гэдэг хуулийн төсөл өмнөх Засгийн үед, парламентын үед явж байсан юм байна лээ. Тэрийг бол 2 салгаад Орон сууцжуулалтын тухай хууль, Орон сууцжуулалтын банкны тухай хууль гээд. Орон сууцжуулалтын тухай хууль нь болохоор яг манай энэ нийлүүлэлт талаа хангасан манай яамны зүгээс илүү түлхүү орж ажиллаж байгаа. Орон сууцжуулалтын банкны тухай хууль дээр болохоор Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, төрийн бус байгууллагууд гээд хамтраад явж байгаа том ажлын хэсэг байгаа. Энэ ажлын хэсгийн хүрээнд 2 хууль маань хамтдаа бичигдээд ерөнхийдөө дууссан. Одоо үзэл баримтлалаа батлуулсан. Харамсалтай нь дахиж батлуулах бас шаардлага гарч байна. Нөгөө Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнд бас өөрчлөлт орсонтой холбоотойгоор бас дахиж батлуулах ийм шаардлага гарч байна.

Барилгын тухай хууль бол 2016 оноос хойш бол бас их олон засгийн үед ингээд шинэчлэгдээгүй явсан. Та сая хэллээ. Тэгэхээр энэ хууль дээр бол манайх хамгийн сүүлийнхээ үе шат буюу яг энэ процессын ажлынхаа сүүлийнхээ үе шатад орчихсон явж байгаа. Энэ дээр бол олон нийтийн хэлэлцүүлгийг хийгээд, дээрээс нь Монголын хуульчдын холбоотой хуулийнхаа агуулга дээр ажиллаад ингээд явж байна.

Нэмэлтээр орсон заалтуудыг манай Одбаяр дарга.

Л.Энхнасан: 5 дугаар микрофон.

О.Одбаяр: Энэ дээр бол орон сууцны бүтэц дээр бид нар бас тодорхой хэмжээнд өөрчлөлт оруулъя гэж байгаа юм. Тэгэхээр яг энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ахмад настан бас мөн хөгжлийн бэрхшээлтэй, өвчтэй хүнээ асран хамгаалдаг энэ өрхүүдэд зориулсан бас орон сууцны ийм бүтээгдэхүүнийг

бол тусад нь нэмэгдүүлье. Энэ дээр бол түрүүчийн хэлдгээр бас халамжийн бодлогыг давхар баримталж явахыг бид нар санал оруулж байгаа. Тэгээд Монголбанк яг Орон сууцны санхүүжилтийн банкны тухай хууль дээр бол бас энэ зүйл заалтуудыг бас тодорхой хэмжээнд тусгасан. Гишүүд маань хэлэлцүүлгийн шатад бол бас санал бодлоо хэлэх бүрэн чөлөөтэй байгаа.

Л.Энхнасан: Баярлалаа гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Асуулт тавьсан гишүүн үгээ хэлнэ. Дэгийн тухай хуулийн 114.1.2-т холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттайгаа холбоотой өөр асуулт асуух ийм заалт байгаа. Ингээд Саранчулуун гишүүн 5 минут үгээ хэлнэ үү.

О.Саранчулуун: Баярлалаа. 1 дүгээрт Байнгын хорооны гишүүддээ бас маш их баярлалаа. Мэдээлэл ирүүлсэн холбогдох мэргэжилтнүүддээ их баярлалаа.

Өнөөдрийн орон сууцын бодлого хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонголт өгч ерөөсөө чадахгүй байгаад байна. Хүний л адилхан хүүхэдтэй, хүүхэд нь сургуульд явдаг, хүн юм чинь ажил хийдэг, ажлын орчин гээд хүмүүс ажилдаа ойрхон, гэр сургуульдаа ойрхон байр хаана байх вэ гэдэг сонголт хийдэгтэй адилхан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч гэсэн ажил хиймээр байна. Үр хүүхдээ сургууль соёл зөөгөөд явмаар байна. Гэтэл нийслэлд баригдаж байгаа, одоо нийслэлийн жишээ дээр аваад үзэхэд хэд хэдэн барилга дээр чи энд л амьдар гэдэг энэ бодлого маань өөрөө бол бас их хол явахгүй. Тэгэхээр үүний үр дүнд бол яамаар байгаа гэхээр ер нь цаашдаа баригдаж байгаа бүх орон сууц өөрөө тодорхой хэсэг нь хүртээмжтэй агуулгатай, 100 байшин байлаа гэхэд 1, 2 нь ч байдаг юм уу хүртээмжтэй, бага орлоготой нийцсэн баймаар байна гэдэг санааг бас хэлэх гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл орон сууцын өнөөдрийн бодлого бол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тусгаарлаж байна гэж би дүгнэх гээд байгаа.

2 дугаарт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зөвхөн байранд орох гээд байгаа юм биш байхгүй юу. Тэр хүмүүс бас гэр хороололд амьдарч байгаа. Тэгэхээр одоо бүх төрлийн ногоон зээлүүд дулаалга, мөн дахин төлөвлөлтийн төслүүдээ өөрийг нь хүртээмжтэй болгоод ирэх юм бол хүмүүс оролцох боломжтой баймаар байгаа байхгүй юу. Яагаад орон сууцад орох гээд байгаа гэхээр тэр хүртээмжгүй байгаа гэр хороололд нэмж бэртэж, гэмтэж, ажил сургуульдаа явах, эмнэлэгтээ явах замд тулдаг 2 дахь бэрхшээлээс л сэргийлэх гээд байгаа юм. Тийм учраас л байр гээд байгаа болохоос биш заавал байр байр гээд байгаа юм биш байхгүй юу. Тэгэхээр аюулгүй байдлыг хайж явж байгаа энэ зүйл маань өнөөдөр байр л болж хувирч байна л даа. Тэгэхээр энэ дээр гэр хорооллын дахин төлөвлөлтүүд болон энэ бүх төрлийн зээлүүдийг өөрийг нь хүртээмжтэй болгочих юм бол хүн өөрийнхөө амьдарч байгаа тэр байшингаа дулаалахдаа хүртээмжтэй болгоод, байр шиг болгоод амьдарчихвал заавал хөгжлийн бэрхшээлтэй хүн болохоороо би байр гээд байгаа юм биш гэдгийг бол бас иргэд ойлгоосой гэж бас бодож байна. Ер нь бодлого хүнд хүрэхгүй бол тэрийг одоо ямар бодлого гэх вэ. Тийм ээ.

3 дугаарт нь өнөөдрийн энэ санхүүгийн систем өөрөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бас ингээд цөөнх гэдгээрээ нэлээн хязгаарлаад байна л даа. Группийн мөнгө авдаг юм чинь гэдэг тэр орлогын чадамжийн судалгааг илүү дэлгэрэнгүй хийх хэрэгтэй байна. 15 мянган хүн өнөөдөр ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй боломжтой байгаа бол ямар ажил хийх боломжтой юм. Ямар боловсролтой юм. Ажил хийдэг хүнийг дэмжье л дээ. Ажилд оруулахын төлөө цалин мөнгийг нь ярьдаг болъё. Эсвэл сонголт өгмөөр байгаа байхгүй юу. Би группийн мөнгөнийхөө оронд юу гэдэг

юм авсан ипотек ч юм уу, байрныхаа зээлд хасаж тооцуулдаг ч юм уу ийм эрсдэлийн сан гэдэг зүйлийг түрүүн Эрдэнэбат гишүүн хөндөж байсан. Энэ чинь гадаадад байдаг л ийм жишиг байхгүй юу. Эрсдэлийн сан гэдэг зүйл. Тэгээд тодорхой хэсгийг нь группийнхээ мөнгөөр ч юм уу, тэтгэврийн мөнгөөр нь урт хугацааны зээлд хамруулаад байранд оруулах ийм гаргалгаануудыг хайсан зүйлүүдийг өнөөдөр бид бид нар шийдэл яримаар байна. Тэгэхгүй бол ингээд ерөөсөө шийдэл байхгүй. Байгаа мөнгө чинь ийм байна тэр мөнгөнд чинь ийм байр олдож байна. Ийшээ орвол ор. Чадахгүй бол боль гэдэг ийм хатуу нөхцөлтэй болохоор чинь хэн орж болох юм. Энэ чинь аягүй асуудалтай байгаад байна.

Хамгийн сүүлд нь 1 хэлмээр байгаа зүйл нь Улаанбаатар хотод маш их орон сууцын барилга, хорооллууд баригдаж байгаа. Тендерийн болон бусад гэрээгээр компаниудтай гэрээ хийгээд орон сууц ашиглалтад орж байгаа. Тэрийг ойлгож байгаа. Гэхдээ энэ дээрээ л өөрсдөө тэр орон нутаг өөрсдөө гэрээ хийхдээ ярьчих л даа. Танай компани юу гэдэг юм. Мянган орон сууц ашиглалтад оруулж байгаа бол 5 хувийг нь жоохон жижиг талбайтай, хүртээмжтэй байлгана шүү. Зогсоолыг нь тэгж төлөвлөнө шүү гэдэг гэрээг өөрөө хийгээд, энийгээ хуульдаа тусгаад ярьчих юм бол болох л асуудал байхгүй юу. Тэгээд дандаа ийм лакшери, тансаг зэрэглэлийн орон сууц гээд учиргүй л их сурталчилгаа байдаг. Яг үзэхээр нөгөө л гялгар плита, нөгөө л нисэж унамаар гулгуур шиг налуу зам нь налуу хийчихсэн, нөгөө хүн багтдаггүй лифттэй. Тэгээд юу нь лакшери гээд байдаг юм гэдэг нь ерөөсөө ойлгомжгүй байхгүй юу.

Уг нь хүртээмж гэдэг чинь өөрөө тансаглал байгаад байгаа байхгүй юу. Бүх хүн ороод гэмтэж бэртдэггүй газрыг л тансаг гэж хэлнэ үү гэхээс биш өөр ямар газрыг тансаг гэж хэлэх гээд байгаа юм. Би ойлгохгүй байгаа. Тэгэхээр цаашдаа яам болон ер нь бодлогын чиглэлийн хүмүүс маань ганц л амлалтыг уг нь хийчихвэл маш том болох гээд байна л даа. Тэр нь юу вэ гэхээр 2026 оноос эхлээд бүх шинэ орон сууц ер нь энэ барилга байгууламж өөрөө хүн ялгахгүй болно гэдэг ийм улс төрийн амлалт, шийдвэрийг л гаргачих л даа. Тэгээд оруулж байгаа хууль, бодлогын баримт бичигтээ тусгаад л явчихмаар байна. Бид нар ч гэсэн энэ талаасаа Саадгүй орчны тухай хууль, өөрсдийнхөө ажиллаж байгаа хуулиараа оролцоод явъя. Та бүхэн ч гэсэн хичээгээд ингээд явчих л даа гэсэн ийм л үгнүүдийг бас хэлмээр байна.

Тэгээд хамгийн эцэст нь энэ дээр хэрвээ боломж байдаг бол тогтоол гаргаж ажиллах ийм бас саналтай байна.

Л.Энхнасан: Баярлалаа. Ингээд гишүүдийн хэлж байгаа саналыг бас яам анхаараарай. Тэр дутуу байгаа мэдээллүүдээ бас гишүүдэд хүргээрэй. Тогтоолыг болбол Улсын Их Хурлын даргын тогтоолоор гарах байх. Энэ Байнгын хороогоор бол гарахгүй юм байна лээ.

Ингээд асуудлыг хэлэлцэж дууслаа. Хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хурал дууссаныг мэдэгдье.

15.47 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ